

ЗӨВШӨӨРСӨН:

ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ц. Зүржбилэг Ц. Зүржбилэг



БАТЛАВ:

НҮД СУДЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Т. АНГАРАА Т. АНГАРАА

ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН
“НҮД СУДЛАЛ”-ЫН ҮНДСЭН
МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ИНДЕКС: S(r) 091211

ХУГАЦАА: 3 жил

УЛААНБААТАР ХОТ
2022 он

НҮД СУДЛАЛ ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛСАН БАГ:

Үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөр боловсруулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ч.Цэнгэлмаа	Эрүүл Мэндийн Яамны Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Монголын хүүхдийн нүд судлал ба хяларын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нүдний мэс заслын тасгийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, Зөвлөх зэргийн эмч;
Д.Уранчимэг	Эрүүл Мэндийн Яамны Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Монголын нүд судлалын Академийн удирдах зөвлөлийн дарга, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Анагаах Ухааны Сургуулийн Нүд судлалын тэнхимийн эрхлэгч, Анагаахын Шинжлэх Ухааны доктор, профессор, Зөвлөх зэргийн эмч;
Т.Анараа	Эрүүл Мэндийн Яамны Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, Ерөнхий мэргэжилтэн, Монголын нүдний эмч нарын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, Монголын торлог шилэнцэрийн эмч нарын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, Сондра нүдний эмнэлгийн захирал, Анагаах ухааны доктор, Клиникийн профессор, Тэргүүлэх зэргийн эмч;
Д.Довчинжамц	Эрүүл Мэндийн Яамны Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Анагаах Ухааны Сургуулийн Нүд судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр;
С.Энхтуул	Эрүүл Мэндийн Яамны Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Монголын нүдний эмч нарын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Нүд судлал, мэс заслын тасгийн эрхлэгч, Тэргүүлэх зэргийн эмч;
З.Баярцэцэг	Монголын нүдний эмч нарын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, Улсын Гуравдугаар Төв Эмнэлгийн Нүдний мэс заслын тасгийн эрхлэгч, Ахлах зэргийн эмч;

Эрүүл мэндийн яамны дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл

Т.Булган	Эрүүл Мэндийн Яамны Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Ази Номхон далайн Нүд судлалын Академийн зөвлөлийн гишүүн, “Нүд судлал” сэтгүүлийн ерөнхий редактор, Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн зөвлөх эмч, Анагаах ухааны доктор, дэд профессор, Зөвлөх зэргийн эмч;
П.Бүрэнжаргал	Эрүүл Мэндийн Яамны Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Нүд

Б.Жавзандулам судлал, мэс заслын тасгийн эмч, Анагаах ухааны магистр, Клиникийн профессор, Зөвлөх зэргийн эмч;
Эрүүл Мэндийн Яамны Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, Нүдний даралтын эмнэлгийн захирал, Анагаах ухааны доктор, Клиникийн профессор, Ахлах зэргийн эмч;

Эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл

М.Алтанхүү Гурван гал эмнэлгийн Нүдний мэс заслын Зөвлөх эмч, Монголын хүүхдийн нүд судлал ба хяларын нийгэмлэгийн ерөнхийлөгч, Анагаах ухааны доктор, Клиникийн профессор;
Ц.Мөнхцэцэг Гэгээн мэлмий нүдний эмнэлгийн Ерөнхий эмч, Анагаах ухааны магистр, Тэргүүлэх зэргийн эмч;
Ц.Мөнхзаяа Сондра нүдний эмнэлгийн Ерөнхий эмч, Монголын торлог шилэнцэрийн эмч нарын нийгэмлэгийн ерөнхийлөгч, Ахлах зэргийн эмч;
М.Мөнхсайхан Болор мэлмий нүдний эмнэлгийн Ерөнхий эмч, Монголын торлог шилэнцэрийн эмч нарын нийгэмлэгийн дэд Ерөнхийлөгч, Ахлах зэргийн эмч;
Г.Нарангарав Солонго нүдний эмнэлгийн Ерөнхий эмч, Анагаах ухааны магистр, Клиникийн профессор;
Д.Сайнбилиг Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Нүд судлал, мэс заслын тасгийн эмч, Тэргүүлэх зэргийн эмч;
А.Тамир Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Монгол-Япон эмнэлгийн их эмч;
Б.Мөнххишиг Сондра нүдний эмнэлгийн эмч, Монголын торлог шилэнцэрийн эмч нарын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, Анагаах ухааны магистр, Ахлах зэргийн эмч;
О.Наранцэцэг Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Нүд судлал, мэс заслын тасгийн эмч, Анагаах ухааны магистр, Тэргүүлэх зэргийн эмч;
Т.Энхзаяа Улсын Гуравдугаар Төв Эмнэлгийн Нүдний мэс заслын тасгийн эмч, Анагаах ухааны магистр;
Н.Мөнхзул Улсын Гуравдугаар Төв Эмнэлгийн Нүдний мэс заслын тасгийн их эмч, Ахлах зэргийн эмч;
Т.Ариунболд Орбита нүдний эмнэлгийн нүдний гэмтэл, нөхөн сэргээх мэс заслын эмч;

Монголын Нүдний эмч нарын нийгэмлэгийн төлөөлөл

П.Баясгалан Монголын нүдний эмч нарын нийгэмлэгийн тэргүүн, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Анагаах Ухааны Сургуулийн Нүд судлалын тэнхимийн багш, Анагаах ухааны магистр, Ахлах зэргийн эмч;
Д.Энхзул Монголын нүдний эмч нарын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Нүд судлал, мэс

- заслын тасгийн эмч, Анагаах ухааны магистр, Тэргүүлэх зэргийн эмч;
- М.Шамсия Монголын нүдний эмч нарын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Нүдний мэс заслын тасгийн эмч, Анагаах ухааны магистр, Тэргүүлэх зэргийн эмч;
- Б.Оюунгэрэл Монголын нүдний эмч нарын нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, Улсын Гуравдугаар Төв Эмнэлгийн Нүдний мэс заслын тасгийн эмч, Анагаах ухааны магистр;

ХЯНАСАН:

- П.Эрхэмбаяр Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр;
- Б.Туяа Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын хүний нөөцийн мэргэшил, сургалт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Д.Дондогмаа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн, Анагаах ухааны магистр;

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2022 оны 09 дүгээр сарын 09 -ний өдрийн
19 дүгээр тогтоолоор зөвшөөрөв.

ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН “НҮД СУДЛАЛ” ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Энэхүү баримт бичгийг Монгол Улсын Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах” тухай А/774 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд, ЭМЯ-ны төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон Нүд судлалын дэд ажлын хэсэг, ЭМЯ-ны дэргэдэх Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөл хамтран боловсруулсан болно.

Хүний их эмчийн “Нүд судлал” үндсэн мэргэшлийн (цаашид резидентийн гэх) сургалтын хөтөлбөрийг Нүд судлалын Олон улсын Зөвлөлийн резидентийн сургалтын хөтөлбөрийн агуулгад нийцүүлж, эмнэл зүйн мэргэшүүлэх сургалт явуулах эрх бүхий үндсэн байгууллага болон сүлжээнд нэгдсэн бусад эмнэлгүүдийн хөтөлбөр хариуцсан эмч, мэргэжилтнүүдийн саналд үндэслэн боловсронгуй болгож, өөрчилсөн.

Нүд судлалын резидентийн сургалтын хөтөлбөрөөр суралцагчдад суурь болон стандарт, ахисан түвшний шат дараалсан онолын мэдлэг, эмнэлзүйн дадлага олгох хичээлийн агуулга, заавал эзэмшвэл зохих ур чадварын суурь шаардлагыг тодорхойлж, оновчтой сургалт явуулахад шаардлагатай эмнэлзүйн орчин, нөхцөл, сургагч багш, эмч мэргэжилтнүүдийн нөөцийн хуваарилалт, гүйцэтгэл, суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний арга зүйг боловсруулсан.

Нүд судлалын чиглэлээр үр дүнтэй, аюулгүй дадлага хийхэд шаардагдах онолын мэдлэг, мэргэжлийн ур чадвар, судалгааны арга зүй, хүн амын нүдний эрүүл мэндийн асуудал нь сургалтын хөтөлбөрийн салшгүй хэсэг бөгөөд энэхүү хөтөлбөрийг боловсруулахдаа өөрийн орны онцлог хэрэгцээ, нөөцийг харгалзан үзсэн болно.

Нүдний эмчийн резидентийн сургалт нь дадлагажигчийг тухайн мэргэжлээрээ аюулгүй, бие даасан эмч болоход бэлтгэнэ.

Сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулах үндсэн урьдач нөхцөл нь улс орон даяар нэгдсэн, шинэчлэгдсэн сургалтын цөм хөтөлбөртэй байх явдал юм.

Энэхүү сургалтын хөтөлбөрийг ЭМЯ-ны Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн Зөвлөл, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ажлын алба болон Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлөөс хүлээн зөвшөөрсөн.

Нүд судлалын салбарын хэд хэдэн Нийгэмлэгүүдээс резидентийн сургалтын хөтөлбөрийг нэгдсэн цөм хөтөлбөрийн дагуу, одоо байгаа хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай, зүй зохистой хуваарилах замаар явуулах талаар саналаа ирүүлсэн.

Энэхүү баримт бичиг нь нүд судлалын резидентийн сургалт явуулж буй эрүүл мэндийн байгууллагуудад хожим шаардлагатай байж болох зарим нэмэлт

мэдээллүүдийг өөрчилж болох зөвлөмжүүдийг толилуулж байна. Сургалтын хөтөлбөр нь нүдний эмчийн үр дүнтэй, аюулгүй дадлага хийхэд шаардагдах мэдлэг, ур чадварыг баримтжуулсан бөгөөд манай орны нийгэм, эдийн засгийн орчин, өвчин эмгэгийн тархалт, эмнэл зүйн хэв шинжийг харгалзан үзсэн болно.

Энэхүү сургалтын хөтөлбөр нь жам ёсны дагуу дэлхий дахины анагаах ухааны хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхах динамик шинж чанартай болохыг онцолж байна. Баримт бичиг нь анагаах ухааны эмнэлзүйн нотолгоонд суурилсан гэдгээрээ ач холбогдолтой. Сургалтын хөтөлбөр нь нүдний эмгэгийн оношилгоо, эмчилгээ, төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн боловсролын онол, дадлагын хамгийн бага шаардлагуудыг тусгасан болно. Сургалтын хөтөлбөрт судалгааны арга зүй, эмчийн ёс зүй, мэргэжлийн ур чадвар, чадамж, хүн амын нүдний эрүүл мэндийг цогц байдлаар багтаасан. Эмнэлгийн удирдлага, практик удирдлага, санхүүгийн менежмент зэрэг менежментийг сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг болгохыг зөвлөж байна. Энэ нь сургалтын хэрэгсэл, нөөцөд тавигдах шаардлага, хүний нөөцийн шаардлагыг тодорхойлно.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Нүд судлалын үндсэн мэргэшлийн чиглэлээр анагаах ухааны нотолгоонд суурилсан онолын мэдлэг, эмнэл зүйн ур чадвар, хууль эрх зүй, эмчийн ёс зүй, харьцаа хандлага зэрэг олон бүрэлдэхүүн хэсгийг агуулсан цогц чадамж бүхий мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Хүн амыг сохролоос сэргийлэх, нүд түүний дайврын эмгэгүүдийн оношилгоо, эмчилгээ, судалгааг өөрийн мэдлэг, ур чадварыг бүрэн дайчлан, цогц байдлаар шийдэх чадамж бүхий, ёс зүйн хэм хэмжээг чандлан баримталдаг гол цөм, багана болж ажиллах Нүд судлалын мэргэшсэн эмчийг бэлтгэх.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Алсын харааг биелүүлэхэд чиглэсэн дараах цогц чадамжтай байна:

1. Нүд судлалын эмч байх (Ophthalmologist)
2. Мэргэжлийн байх (Professional)
3. Тасралтгүй суралцагч байх (Continous Learner)
4. Харилцагч байх (Communicator)
5. Хамтрагч байх (Collaborator)
6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байх (Community Health Advocate)
7. Зохион байгуулагч, манлайлагч байх (Leader)

Энэхүү цогц чадамж нь нүдний эмчийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, хандлагын тухай ойлголт юм. Үүнд:

- 1. Нүд судлалын эмч байх (Ophthalmologist)**

- Хүн амыг сохролоос сэргийлэх, нүд ба түүний дайврын эмгэгүүдийн урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, судалгаа, шинжилгээг өөрийн мэдлэг, ур чадварыг бүрэн дайчлан, цогц байдлаар шийдэх чадамж бүхий, ёс зүйн хэм хэмжээг чандлан баримталдаг эмч байх;
 - Нүд судлалын салбарт өөрийн мэргэшлээр хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй, үүргээ ухамсарладаг байх;
- 2. Мэргэжлийн байх (Professional)**
- Тусламж үйлчилгээг чанарын өндөр түвшинд үзүүлэх, мэргэжилтэн хоорондын харилцаанд тохиромжтой зан төлөвийг баримтлаж ажиллах чадварууд;
 - Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах;
 - Үйлчлүүлэгч, хамтран ажиллагсад, суралцагчийн бие хүний хөгжил ба зан байдлыг өөрчлөхүйц зөвлөгч байх;
 - Мэдлэг, чадвар, мэргэжлийн зан төлөвөө тохиромжтой түвшинд барьж сайжруулах;
 - Тусламж үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлөх нийгэм, соёл, шашны асуудлуудыг ухамсарлах;
 - Үйлчлүүлэгчийн эмгэг байдал, авч байсан тусламж үйлчилгээнүүд болон эрүүл мэндийн байгууллагуудтай харилцаж байсан харилцааны талаарх өмнөх түүхийг анхаарах;
 - Үйлчлүүлэгч, үйлчлүүлэгсдийн эрхийг мэддэг, хүндэлдэг байх;
 - Эмгэг байдал нь үйлчлүүлэгчийн хараат бус байдал, нэр хүндэд нөлөөлж болохыг ойлгодог байх;
 - Эмнэлзүйн шийдвэр гаргахдаа үйлчлүүлэгчийн хүсэлт, сонголт хамгийн чухал болохыг мэддэг байх;
 - Мэргэжлийн үйл ажиллагааны стандартууд, хууль тогтоомжоор үйлчлүүлэгчийн нууцлалын зарчим, хязгаарлалт тодорхойлогддог болохыг анхааралдаа авч, эмнэлзүйн мэдээллийг зөвхөн үйлчлүүлэгчийн зөвшөөрлөөр аман болон бичгэн хэлбэрээр бусадтай хуваалцдаг, үйлчлүүлэгчийн мэдэхгүй байх эрхийг хүндэтгэдэг байх;
 - Тусламж үйлчилгээ үзүүлэхдээ үнэнч, шударга, хариуцлагатай, найдвартай, өрөвч нигүүлсэнгүй, энэрэнгүй сэтгэлтэй, мэргэжлийн ёсзүйн өндөр түвшинд ажиллах;
 - Хувийн болон мэргэжлийн үүргийн тохиромжтой харьцааг баримтлан үүсч болох ашиг сонирхлын зөрчлийн талаар ойлголттой, сэргийлж чаддаг байх;
 - Эмч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангах;
 - Өдөр тутмын ажилдаа анагаах ухаан, хууль зүй, мэргэжлийн хэм хэмжээг хүндэтгэн, ёс зүйн хариуцлагаа ухамсарлан ажиллах чадварууд;
 - Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
 - Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг бүрэн судлан, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах;

- Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээг дээд зэргээр баримтлах
- Өөрийн хувь хүний болон мэргэжлийн бүхий л боломжоо гарган үйлчлүүлэгчдэд зөвлөгч нь байх;
- Үйлчлүүлэгч, түүний асран хамгаалагч нар нь өөрсдийн нөхцөл байдлаа ойлгох, асуудлыг тодруулах, зохицуулах, үүссэн саад бэрхшээлийг даван туулах, шаардлагатай үед нөхцөл байдлаа өөрчлөхөд нь туслах чадвар;
- Цочрол, стрессд орох, хэн нэгнээ алдсан гашуудал, архи мансууруулах бодист донтох, ажил мэргэжлийн холбоотой асуудал, осол гэмтэлд өртөх, өвчнөөс үүссэн бэрхшээл зэргийг давж гарахад зөвлөгч байх чадвар;
- Өөрийн мэргэжлийн түвшин, хувийн алдаа дутагдлаа мэддэг бөгөөд үйлчлүүлэгчийн тусын тулд ажиллах ёс зүйн зарчмыг баримталдаг байх;
- Үйлчлүүлэгчид хамаатай бүх зүйл, амьдралын шийдвэрлэх асуудлыг чандлан нууцалж, шаардлагатай нөхцөлд зөвшөөрөл авах;
- Үйлчлүүлэгчид анхаарал халамж тавьж буйгаа биеийн хэлцэмж, үг хэлээр илэрхийлж, дотоод ертөнцөд нэвтрэн орох, асуудлыг шийдвэрлэхийг үнэн сэтгэлээсээ хүсч байгаа эерэг харилцаа үүсгэх чадвар;
- Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийн эерэг ба сөрөг бүх хариу үйлдэлд тэвчээртэй хандснаар үйлчлүүлэгчид эерэгээр нөлөөлөх чадвар;

3. Тасралтгүй суралцагч байх (Continous Learner)

- Тасралтгүй сургалтын хувийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, баримтжуулах чадвар;
 - Өөрийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтанд хамрагдах;
 - Мэдлэг ур чадвараа байнга хөгжүүлэх, дээшлүүлэх хүсэл эрмэлзэлтэй байх;
 - Сурах, мэдэхийн ашиг тусыг ойлгож, мэдэрсэн, олж харсан, идэвхитэй, мэрийлттэй байх;
 - Өөрийн мэдлэг, ур чадвараа нэмэгдүүлж, авъяасаа хөгжүүлэхэд шаардагдах урт хугацааны цаг завьг зохицуулах чадвар;
- Анагаах ухааны чиглэлээр тулгарч буй асуудалд шинжлэх ухаанч асуулт тавих, шүүмжлэлтэй хандах, эмнэлзүйн шийдвэр гаргалтанд шинжлэх ухааны нотолгоог ашиглах чадварууд;
 - Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх;
 - Судалгаа шинжилгээ хийж түүний үр дүнг эмнэлзүйн дадал, онолын мэдлэгийг цаашид хөгжүүлэхэд ашиглах чадвартай, хүсэл эрмэлзэлтэй байх;
 - Дүн шинжилгээг эмнэлзүйд ашиглах боломжийг судлах, ашиглах;

- Шинэ нөхцөл байдалд өөрийн туршлага, мэдлэг, дадлыг хөрвүүлэн ажиллах чадвар;
- Хийсвэр үзэл баримтлал, онолын мэдлэгийг эмнэлзүйд тусган ажиллаж, ерөнхий дүгнэлт гаргах чадвар;
- Шинжлэх ухаанч асуулт тавих ерөнхий зарчим, биостатистикийн үндэсийг мэддэг байх;
- Үйлчлүүлэгч, оюутан, эрүүл мэндийн бусад мэргэжилтний сурах үйл ажиллагааг дэмжих чадвар;
 - Мэдлэг, ур чадвараа хуваалцах хүсэл эрмэлзэлтэй, түүнийгээ ирээдүй хойч үеийн эмч нар, бусад ажилтнуудад зааж өгөх чадвартай байх;
 - Суралцагчийн чадварыг бодитоор үнэлэх чадвартай байх;
 - Мэргэжлийн хүрээнд гарын авлага, танилцуулга, сургалтын материал, ном, сурах бичиг хянан тохиолдуулах, бүтээх;
 - Сургалтын орчин бий болгох;
 - Ахмад эмчийг дагалдах, бусдыг дагалдуулан суралцуулах ур чадвар;
- Шинэ мэдлэг бий болгох, түгээх, ашиглах чадварууд;
 - Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг, ур чадвараа сайжруулах;
 - Салбар дундын ижил мэргэжилтний дунд хурал, семинар, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулах, хөтлөх чадвар;
 - Судалгааны төсөл бичих, төсөл удирдах, хамтарсан төсөлт ажилд оролцох, эрдэм судлалын ажил хийж өөрийгөө хөгжүүлэх;
 - Шинэ мэдлэгийг хамтран ажиллагсад, бусад харилцагчдаа түгээх, өдөр тутмын ажилдаа нэвтрүүлэх;

4. Харилцагч байх (Communicator)

- Үйлчлүүлэгч түүний гэр бүлд шаардлагатай мэдээлэл өгөх, итгэл төрүүлэх, ёс зүйтэй эмнэлзүйн харилцаа үүсгэх чадварууд;
 - Өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах;
 - Ёс зүйн хэм хэмжээг баримтлах;
 - Аман бус харилцааны шинжүүдийг (биеийн хэлцэмж, нүдний харц, гар барих байдал, дууны өнгө, нөхөрсөг өнгөөр ярилцах гэх мэт) бүрэн эзэмших;
 - Нүдний эмгэг, эмчилгээний менежмент, болзошгүй үр дагаврын талаар өвчтөн, түүний төрөл садантай харилцах чадвартай байх;
 - Өөртөө итгэлтэй байдлыг энгийн даруу байдлаар харуулах чадвар;
 - Бусдын зовлонг ойлгох чадвар эзэмших;
 - Хүндлэлийг эзэмших;
- Үйлчлүүлэгч түүний гэр бүл, хамт олон болон бусад мэргэжлийн хүмүүст холбогдох мэдээлэл, тайлбарыг танилцуулж, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцон, төлөвлөгөө боловсруулах чадварууд;
 - Шаардлагатай тохиолдолд өвчтний оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх;

- Шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах;
- Сайн сонсогч байх;
- Нөхөрсөг байдлыг бий болгох;
- Харилцааны зөв арга хэрэгслийг (биечлэн уулзах, цахим шуудан явуулах гэх мэт) ашиглаж мэдэх;
- Харилцааны дүнд бий болсон үл ойлголцлыг хувиргаж чадах чадвар эзэмших;
- Нээлттэй байдлыг бий болгох;
- Зохистой байдлаар эргэх холбоо үүсгэх ур чадвартай байх;
- Үйлчлүүлэгчийн талаарх мэдээллийг бичгээр болон амаар үнэн зөв дамжуулах чадварууд:
 - Үг, үсэг, дүрмийн алдаагүй, зөв утгатай бичих чадвар;
 - Өвчний түүх, үйлчлүүлэгчийн карт, албан бичгийг журам, стандартын дагуу бичих чадвар;
 - Зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах;
 - Эмч нь өвчний үе шат, үр дагавар төгсгөлийн талаархи мэдээллийг үнэн зөв тайлагнах;

5. Хамтрагч байх (Collaborator)

- Үйлчлүүлэгчид чанартай, аюулгүй тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор удирдлага, эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй зөвшилцөн, багаар ажиллах чадварууд:
 - Тухайн үйлчлүүлэгчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар тасгийн мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах;
 - Тухайн орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар бусад эмнэлгийн мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцож, хамтран ажиллах;
 - Дээд шатны байгууллага, их сургууль, нийгэмлэг, зөвлөлтэй мэдээлэл солилцох, хамтран ажиллах;
 - Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг бууруулахгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулахын тулд өөрийн хамтран ажиллагсадтай байнгын холбоотой, сүлжээ үүсгэн ажиллах чадвартай байх;
 - Үүссэн үл ойлголцол, саад бэрхшээлийг шийдэл ба боломж болгон хувиргахын тулд уян хатан байх чадварыг эзэмших;
 - Өөрийн мэргэжлийн дутагдалтай байдлыг хүлээн зөвшөөрч, үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээнд бусдын тусламжийг авах;
 - Өвчтөн болон эмч нарын зүгээс өөрийн ажлын чанартай холбоотой санал хүсэлт, ирсэн сөрөг саналыг хүлээн авах чадвар;
- Салбар дундын багийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох чадварууд:
 - Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах;

- Салбар дундын ижил мэргэжилтний дунд хурал, семинар, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулах, хөтлөх чадвар;
- Эмнэлгийн бусад мэргэжилтэн, ажилтнуудтай ажил хэрэгч, үр бүтээлтэй харьцах чадвартай байх;
- Багийн үйл ажиллагаанд хувийн үүрэг хариуцлагаа хүлээж ажиллах;
- Өөрийн үйлчлүүлэгчийн хяналтын талаар сувилагчид зааж хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх;

6. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (Community Health Advocate)

- Монгол улсын нийт хүн амын болоод хувь хүний эрүүл мэндийг сахин хамгаалахад чиглэсэн хүчин чармайлт гаргах чадварууд;
 - Хувь хүнийг эдгээн илааршуулах, эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг таних, үнэлэх, эрсдлийг бууруулах, нөөцийг дайчлах арга хэмжээг зохион байгуулах;
 - Хувь хүний эрүүл, эмгэг зан үйлийг таних, үнэлэх чадвар, эрүүл мэндийг дэмжих асуудал нь үйлчлүүлэгчийн эмчилгээний салшгүй хэсэг болохыг ойлгох;
 - Өвчин эмгэг, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх тохиромжтой үйл ажиллагааг зохион байгуулах, хувь хүн, гэр бүл, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах, хадгалах, дэмжих, үүрэг, боломжоо ухамсарласан байх;
 - Хувь хүний эрүүл мэндийн өмнө хүлээсэн эрүүл мэндийн зөвлөгчийн үүрэг ба олон нийтийн эрүүл мэндийн өмнө хүлээсэн хаалга баригчийн үүргийн хооронд зөрчил үүсч болох тухай мэддэг байх;
- Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж зөвлөгөө өгөх чадварууд;
 - Эмч тархвар судлалын баримтанд үндэслэн олон нийтийн эрүүл мэндийн хэрэгцээг тодорхойлох;
 - Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндэд нийгмийн бодлогууд хэрхэн нөлөөлж байгааг өргөн цар хүрээтэйгээр тодорхойлох;
 - Эмч эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангах;

7. Зохион байгуулагч, манлайлагч байх (Leader)

- Өөрийн сургалтын хэрэгцээ, хувийн амьдрал, эрүүл мэндийн байдалдаа цаг хугацаа боломжит нөөцийг үр дүнтэйгээр ашиглах чадвар;
 - Сонгосон мэргэшилдээ үнэнч, нийгэмд өөрийн хувь нэмэр оруулах хүсэл эрмэлзэлтэй байх;
 - Цаг ашиглалтыг дээд хэмжээнд барьдаг байх;
 - Мэргэжлийн үр дүнтэй дадлага хийхийн тулд менежмент, эрэмбэлэх чадварыг эзэмшсэн байх;
 - Өөрийн мэдлэг, ур чадвараа тасралтгүй сайжруулах, дээшлүүлэх хүсэл, чадвартай байх;

- Ажлын хэт ачаалал, сэтгэл түгшилтээс үүдэн өөрт тохиолдох өвчин эмгэгийг эрт үеийн шинж тэмдгээр таньж өөрийн эрүүл мэндээ хамгаалах;
- Ажлын тэргүүлэх чиглэлээ тодорхойлж цагийг үр дүнтэй төлөвлөж хувийн зохион байгуулалттай ажиллах;
- Үйлчлүүлэгчийн нэн тэргүүний хэрэгцээнд үндэслэн эрүүл мэндийн тусламжийн хязгаарлагдмал нөөц бололцоогоо ахмад эмчийн хяналт дор ашиглах чадварууд;
 - Сайн сонсогч байх;
 - Ахмад эмчийн зөвлөгөөг өөрийн нөхцөл бололцоонд тааруулж тусган ажиллах чадвар;
- Эрүүл мэндийн байгууллагад үр ашигтай, бүтээлчээр ажиллах чадварууд;
 - Мэргэшсэн байх, өөрийн мэдлэг, ур чадварыг бүрэн дүүрэн ашиглах чадвар;
 - Нүдний эмгэг, түүний мэс засал болон оптикийн асуудлыг шийдвэрлэхүйц эмнэлзүйн зөв дүгнэлт хийх мэдлэг, чадвартай байх;
 - Хүнлэг энэрэнгүй, эмч эмнэлгийн ажилтны ёс зүйг дээд зэргээр баримтлан ажиллах чадвар;
 - Мэргэжил, ур чадварыг ямагт хөгжүүлэн суралцах;
- Салбар хоорондын багийн үйл ажиллагаанд үр дүнтэйгээр оролцох чадварууд;
 - Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах;
 - Салбар дундын ижил мэргэжилтний дунд хурал, семинар, хэлэлцүүлэг тогтмол зохион байгуулах, хөтлөх чадвар;
- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах чадварууд;
 - Хувь хүний онцлог, амьдралын байдлыг харгалзан өвчтөн болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, садан, төрлийн хүнтэй хүндэтгэлтэй харьцах;
 - Хүн амын дунд зонхилон тохиолддог, зайлшгүй сохрол, сул хараа үүсгэдэг өвчнүүдийн шинж тэмдгийг таньж, ялган оношилдог, анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлдэг байх;
 - Өвчтнөөс асуумж авах, бодит үзлэг хийх, өвчтөн түүний гэр бүл асран хамгаалагчийн сэтгэл зүй, нийгмийн нөхцөл байдлыг үнэлж оношилгоо, эмчилгээ, хяналтын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлдэг байх;
 - Орон нутгийн түвшинд хийгдэх оношилгоо, эмчилгээний гардан үйлдлүүдийг бүрэн эзэмшиж, тусламж үйлчилгээг аюулгүй үзүүлдэг байх;
 - Өвчтний хувийн нууцыг хадгалах;
 - Өвчтний өвдөлт, сэтгэл зовнил, цаашдын тавиланд анхаарал хандуулж чаддаг байх;

- Орон нутгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний нөөц бололцоонд тулгуурлан, өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээг шийдвэрлэх;
- Өөрийн мэдлэг, боловсролыг бүрэн дайчлан шавхаж ажиллах чадвар;
- Хамгийн оновчтой шийдвэрийг шуурхай гарган ажиллах чадвар;
- Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл, тайлангийн маягтыг зохих хууль журмын дагуу цаг хугацаанд нь үнэн зөв хөтлөх;

ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

5.1. Сургалтын төрөл, хэлбэр, чиглэл, индекс, хугацаа, байршил

- Сургалтын хугацаа 3 жил байна.
- Хүний их эмчийн “Нүд судлал” үндсэн мэргэшлийн сургалт нь Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс Нүд судлал үндсэн мэргэшлийн сургалт явуулах зөвшөөрөл авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага, анагаах ухааны боловсрол олгох их сургуульд түшиглэн явагдана.
- Нүд судлал үндсэн мэргэшлийн эмнэл зүйн мэргэшүүлэх сургалт нь зөвхөн эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагад түшиглэн явагдах бөгөөд тухайн сургалтад гол үүрэгтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага нь үндсэн байгууллага байна. Сургалт эрхлэх үндсэн байгууллага нь
 - Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг
 - Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг
 - Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, түүний харьяа Монгол-Японы сургалтын эмнэлэг байна.
- Сургалт эрхлэх үндсэн байгууллагууд нь өөрийн байгууллагад дангаар хэрэгжүүлэх боломжгүй сургалтыг хамтран зохион байгуулах зорилгоор Эх, Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв, лавлагаа шатлалын бусад эмнэлгүүдтэй сүлжээ үүсгэн хамтран ажиллана.

5.2. Сургалт явуулах арга зүй

- “Нүд судлал” үндсэн мэргэшлийн сургалт нь 132 долоо хоног үргэлжлэх ба ажлын байрны сургалт (On the job), тэнхимийн сургалт (Off the job), нойтон лаборатори (Wet-Lab), дуураймал орчин дахь сургалт (Simulation training) хэлбэрээр явагдана.
- Нүд судлалын үндсэн мэргэшлийн сургалтад мэргэшүүлэх (эмнэл зүйн) болон заавал судлах, сонгон судлах (эмнэл зүйн бус) тойролтууд тус тус багтана.
- Нүд судлалын эмнэл зүйн мэргэшүүлэх сургалт нь 12 тойролтоор явагдана.
- Сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, мэргэжлийн үнэ цэнэ, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууцтай

холбоотой хууль, Эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтанд заавал хамрагдана.

- Тойролт хийх хуваарь, үргэлжлэх хугацааг сургалт эрхлэх үндсэн болон сүлжээ байгуулагуудын байршил, хүчин чадал, нөөцөд тохируулан зохион байгуулна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны нарийвчилсан хуваарийг сургалтын эрхлэх үндсэн байгууллагын сургалтын алба боловсруулж батлуулна.
- Сургалт эрхлэх байгууллага нь сургалтын таатай орчин, дэд бүтцийг бүрдүүлэх, бэхжүүлэх, суралцагчийн ажиллан суралцахтай холбоотой үүсэх хөдөлмөрийн харилцааны нэмэлт зохицуулалтыг байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлэх, тойролтод заасан хуваарилалтын дагуу суралцуулах, сургалтын үйл явцыг үнэлэх, дотоод хяналт тавих ажлыг зохион байгуулна.
- Нүд судлал үндсэн мэргэшлийн сургалтыг явуулахдаа суралцагчийг бие дааж мэргэжлийн үйл ажиллагаа явуулах (сонсох, харах, сургалт удирдах багшийн хяналтан дор гардан үйлдэл хийх, сургалт удирдах багш, эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтарч гардан үйлдэл хийх, бие дааж гардан үйлдэл хийх) чадварыг үе шаттайгаар бүрэн эзэмшүүлэх дадлага голлосон хэлбэрээр хийнэ.
- Нүд судлал үндсэн мэргэшлийн сургалт дүүргэснийг гэрчлэх баримт бичиг нь нүдний судлалын эмчийн мэргэшлийн үнэмлэх байна.

5.3. Зайлшгүй таньж мэдэх, суралцах шаардлагатай шинж тэмдэг ба хам шинж (signs and symptoms), суурь мэдлэг, өвчин эмгэг, эзэмших гардан үйлдэл

Нүд судлал үндсэн мэргэшлийн сургалтад суралцагч нь сургалтын төгсгөлд бие даан тусламж, үйлчилгээ үзүүлж чадах түвшинд хүрэхийн тулд эмнэл зүйн сургагч багшийн шууд хяналт дор суралцан ажиллах явцдаа дараах шинж тэмдэг, хам шинж, өвчин эмгэгийг танин мэдэж, гардан үйлдлийг гүйцэтгэн, үндсэн мэргэшлийн сургалтын тойролтуудад оролцоно.

5.3.1. Зайлшгүй таньж мэдэх өвчний шинж тэмдэг (signs and symptoms):

1. Хараа аажим муудах (*Slow loss of vision*)
2. Хараа эсхүл харааны талбай гэнэт хэсэгчлэн эсхүл түр алдагдах (*Sudden partial or temporary loss of vision or loss of visual field*)
3. Хараа бүрэлзэх, манантах (*Blurred and opaque vision*)
4. Гэрэл мэдрэх төдий харах (*Light perception vision*)
5. Шөнийн харалган (*Night-blindness*)
6. Өнгөний харалган (*Color blindness*)
7. Нүдэнд оч гялбах (*Light flashes / photopsia*)
8. Шулуун зураас муруй долгионтой мэт харагдах (*Straight lines look bent or wavy*)
9. Гэрэл цацарч эсхүл хүрээ татаж харагдах (*Starbursts or halos around lights*)
10. Нүд гэрэлд гялбах (*Photophobia*)

11. Нүдний өмнүүр юм хөвж харагдах (*Floating objects in the eye*)
12. Сүүдэр эсвэл бараан хөшиг хаасан мэт харах (*Shadow or dark curtain in vision*)
13. Юмс жижиг эсхүл хэмжээ нь өөрчлөгдөж харагдах (*Objects appear smaller or different sizes*)
14. Юм хоёрлож харагдах (*Double vision / diplopia*)
15. Төвийн харааны алдагдал (*Central vision loss*)
16. Захын харааны алдагдал (*Peripheral vision loss*)
17. Хялар (*Strabismus*)
18. Мохос хараа (*Amblyopia / lazy eye*)
19. Нүдний дотоод даралт ихсэх (*Increased intraocular pressure*)
20. Нүдний дотоод даралт багасах (*Decreased intraocular pressure*)
21. Гифем (*HypHEMA*)
22. Гипопион (*Hypopyon*)
23. Цочмог үрэвсэл (*Acute inflammation*)
24. Архаг үрэвсэл (*Chronic inflammation*)
25. Толгой өвдөлт (*Headache*)
26. Нүдний өвдөлт (*Pain in eye*)
27. Нүдний цочмог өвдөлт (*Acute eye pain*)
28. Нүдний угаар өвдөх (*Pain behind eye*)
29. Нүдний орчмын өвдөлт (*Pain around eye*)
30. Нүдэнд гадны биет орох/торох (*Foreign body/sandy feeling in the eye*)
31. Нүд загатнах (*Itching eye*)
32. Нүд улайх (*Red eye*)
33. Нулимс гоожих (*Tearing*)
34. Нүд цочрох (*Irritation*)
35. Нүд хуурайших (*Dryness*)
36. Нүд нуухтах (*Discharge from eye*)
37. Нүд халуун оргих (*Burning in the eye*)
38. Зовхины агчил (*Blepharospasm*)
39. Зовхины үүсгэвэр (*Lump on eyelid*)
40. Зовхины хөдөлгөөн хязгаарлагдах (*Limited movement of eyelid*)
41. Зовхи унжих (*Drooping eyelid*)
42. Нүдний хэвийн бус хөдөлгөөн (*Abnormal eye movement*)
43. Нүд бүлтийх (*Exophthalmos /proptosis*)
44. Хүүхэн харааны эмгэг байдал (*Abnormalities of pupil*)
45. Хүүхэн хараа томрох (*Enlarged Pupil*)
46. Нүдний гэмтэл (*Eye trauma*)
47. Зовхи хавдах (*Swollen eyelid*)
48. Эвэрлэгийн хаван (*Corneal edema*)
49. Өмнөд хорго гүехэн болох (*Shallow anterior chamber*)
50. Өмнөд хоргод эс эсхүл хөвөлт үүсэх (*Cells or floaters on anterior chamber*)
51. Амьсгал, цусны эргэлтийн зогсолт (*Cardiac Arrest*)
52. Шигдээс (*Infarction*)
53. Ухаан алдалт, баларталт (*Convulsions, Syncope*)
54. Оворго (*Coma*)

55. Шок (*Shock*)
56. Амьсгаадалт (*Shortness of breath*)
57. Цээжээр өвдөлт (*Chest pain*)
58. Амьсгал осолтой зүрхний хэм алдагдалт (*Life threatening Arrhythmia*)
59. Цус алдалт (*Bleeding*)
60. Таталт (*Seizures*)
61. Халууралт (*Fever*)
62. Дотор муухайралт, бөөлжилт (*Nausea, vomit*)
63. Сэтгэл гутрал (*Depression*)
64. Манас таталтын хам шинж (*Eclampsia*)
65. Хордлогын хам шинж (*Poison syndrome*)

5.3.2. Зайлшгүй суралцаж, таньж мэдэх шаардлагатай өвчин эмгэгүүд:

Зовхи, нулимсны эрхтэн, ухархайн эмгэгүүд (*Disorders of eyelid, lacrimal system and orbit*). H00-H06

1. Өвдөг ба халазион (*Hordeolum and chalazion*). H00
2. Блефарит (*Blepharitis*). H01.0
3. Зовхи дотогш шамрах ба сормуусны буруу ургах (*Entropion and trichiasis of eyelid*). H02.0
4. Зовхи гадагш шамрах (*Ectropion of eyelid*). H02.1
5. Лагофталм (*Lagophthalmos*). H02.2
6. Блефарохалазис (*Blepharochalasis*). H02.3
7. Зовхи буух (*Ptosis of eyelid*). H02.4
8. Блефарофимоз (*Blepharophimosis*). H02.52
9. Зовхины Мейбомын булчирхайн үйл ажиллагааны алдагдал (*Meibomian gland dysfunction of eyelid*). H02.88
10. Дакриоаденит (*Dacryoadenitis*). H04.0
11. Нүд хуурайших хам шинж (*Dry eye syndrome*). H04.12
12. Цочмог дакриоцистит (*Acute dacryocystitis*). H04.32
13. Архаг дакриоцистит (*Chronic dacryocystitis*). H04.41
14. Нярайн хамар нулимсны хүүдийн бөглөрөл (*Neonatal obstruction of nasolacrimal duct*). H04.53
15. Нулимсны сүв урвах (*Eversion of lacrimal punctum*). H04.52
16. Нулимсны сувгийн нарийсал (*Stenosis of lacrimal canaliculi*). H04.54
17. Нулимсны цэгийн нарийсал (*Stenosis of lacrimal punctum*). H04.56
18. Ухархайн целлюлит (*Cellulitis of orbit*). H05.01
19. Нүд бүлтийх байдал (*Exophthalmic conditions*). H05.2
20. Ухархайд цус хурах (*Hemorrhage of orbit*). H05.23
21. Нүд ширгэх (*Enophthalmos*). H05.4
22. Ухархайн нэвт шархны улмаас ухархайд орсон (удаж буй) гадны биет (*Retained (old) foreign body following penetrating wound of orbit*). H05.5

Налихын эмгэгүүд (*Disorders of conjunctiva*). H10-H11

23. Цочмог конъюнктивит (*Acute conjunctivitis*). H10.01
24. Архаг конъюнктивит (*Chronic conjunctivitis*). H10.4
25. Блефароконъюнктивит (*Blepharconjunctivitis*). H10.5

- 26. Нүдний далавч хальс (*Pterygium of eye*). H11.0
- 27. Нүдний өөх (*Pinguecula*). H11.15
- 28. Налих сорвижих/Симблефарон (*Symblepharon*). H11.23
- 29. Налихын цус харвалт (*Conjunctival hemorrhage*). H11.3

Нүдний склер, эвэрлэг, солонгон бүрхүүл ба сормослог биеийн эмгэгүүд (Disorders of sclera, cornea, iris and ciliary body). H15-H22

- 30. Склерит (*Scleritis*). H15.0
- 31. Склеромаляци (*Scleromalacia*). H15.05
- 32. Эписклерит (*Episcleritis*). H15.1
- 33. Кератит (*Keratitis*). H16
- 34. Эвэрлэгийн шарх (*Corneal ulcer*). H16.0
- 35. Кератоконъюнктивит (*Keratoconjunctivitis*). H16.2
- 36. Эвэрлэгийн абсцесс (*Corneal abscess*). H16.31
- 37. Эвэрлэгийн шинэ судасжилт (*Corneal neovascularization*). H16.4
- 38. Эвэрлэгийн сорвижилт ба үүл (*Corneal scars and opacities*). H17
- 39. Бэлцрүүт кератопати (*Bullous keratopathy*). H18.1
- 40. Кератоконус (*Keratoconus*). H18.6
- 41. Цочмог ба цочмогдуу иридоциклит (*Acute and subacute iridocyclitis*). H20.0
- 42. Архаг иридоциклит (*Chronic iridocyclitis*). H20.1
- 43. Фуксийн гетерохроми циклит (*Fuchs' heterochromic cyclitis*). H20.81
- 44. Вогт Кояанаги хам шинж (*Vogt-Koyanagi syndrome*). H20.82
- 45. Гифем (*HypHEMA*). H21.0
- 46. Солонгон бүрхүүлийн рубеоз (*Vascular disorders of iris / rubeosis*). H21.1
- 47. Солонгон бүрхүүлийн хатингар (*Iris atrophy*). H21.26
- 48. Хүүхэн харааны сарьс (*Pupillary membranes*). H21.4
- 49. Солонгон бүрхүүл, сормослог биеийн наалдац, урагдал (*Adhesions and disruptions of iris and ciliary body*). H21.5
- 50. Өөр бүлэгт ангилсан өвчний үеийн солонгон бүрхүүл ба сормослог биеийн эмгэг (*Disorders of iris and ciliary body in diseases classified elsewhere*). H22

Болрын эмгэгүүд (Disorders of lens). H25-H28

- 51. Хөгшрөлтийн болрын цийлт (*Age-related cataract*). H25
- 52. Нярайн ба өсвөр насны болрын цийлт (*Infantile and juvenile cataract*). H26.0
- 53. Гэмтлийн цийлт (*Traumatic cataract*). H26.1
- 54. Хүндрэлийн цийлт (*Complicated cataract*). H26.2
- 55. Эмийн гаралтай цийлт (*Drug induced cataract*). H26.2
- 56. Болоргүйдэх (*Aphakia*). H27.0
- 57. Болрын мултрал (*Dislocation of lens*). H27.1
- 58. Өөр бүлэгт ангилсан өвчний үеийн цийлт ба болрын бусад эмгэг (*Cataract in diseases classified elsewhere*). H28

Судаслаг бүрхүүл ба торлогийн эмгэгүүд (Disorders of choroid and retina). H30-H36

- 59. Судаслаг бүрхүүл, торлогийн үрэвсэл (*Chorioretinal inflammation*). H30
- 60. Арын циклит (*Posterior cyclitis*). H30.2
- 61. Судаслаг бүрхүүл, торлогийн сорви (*Chorioretinal scars*). H31.0

62. Судаслаг бүрхүүлийн сөнөрөл (*Choroidal degeneration*). H31.1
63. Судаслаг бүрхүүлийн удамшлын дистрофи (*Hereditary choroidal dystrophy*). H31.2
64. Судаслаг бүрхүүлийн цус харвалт ба урагдал (*Choroidal hemorrhage and rupture*). H31.3
65. Судаслаг бүрхүүлийг түрсэн цус хуралт (*Expulsive choroidal hemorrhage*). H31.31
66. Судаслаг бүрхүүлийн хуурал (*Choroidal detachment*). H31.4
67. Судаслаг бүрхүүлийн шүүдэст хуурал (*Serous choroidal detachment*). H31.42
68. Өөр бүлэгт ангилсан өвчний үеийн судаслаг бүрхүүл, торлогийн эмгэгүүд (*Chorioretinal disorders in diseases classified elsewhere*). H32
69. Торлогийн хуурал ба язрал (*Retinal detachments and breaks*). H33
70. Торлог цавтах ба торлогийн ууланхай (*Retinoschisis and retinal cysts*). H33.1
71. Торлогийн шүүдэст хуурал (*Serous retinal detachment*). H33.2
72. Торлог хууралгүй язрах (*Retinal breaks without detachment*). H33.3
73. Торлогийн хууралгүй, тах хэлбэрийн урагдал (*Horseshoe tear of retina without detachment*). H33.31
74. Торлогийн татагдсан хуурал (*Traction detachment of retina*). H33.4
75. Торлогийн төв артерийн бөглөрөл (*Central retinal artery occlusion*). H34.1
76. Торлогийн артерийн салааны бөглөрөл (*Retinal artery branch occlusion*). H34.23
77. Торлогийн төв венийн бөглөрөл (*Central retinal vein occlusion*). H34.81
78. Торлогийн венийн салааны бөглөрөл (*Branch retinal vein occlusion*). H34.83
79. Шүүдэст ретинопати (*Exudative retinopathy*). H35.02
80. Гипертензийн ретинопати (*Hypertensive retinopathy*). H35.03
81. Торлогийн васкулит (*Retinal vasculitis*). H35.06
82. Дутуу нярайн ретинопати (*Retinopathy of prematurity*). H35.1
83. Насжилтын шалтгаант шар толбоны шүүдэст бус сөнөрөл (*Nonexudative age-related macular degeneration*). H35.31
84. Насжилтын шалтгаант шар толбоны шүүдэст сөнөрөл (*Exudative age-related macular degeneration*). H35.32
85. Шар толбоны цэврүүт сөнөрөл (*Cystoid macular degeneration*). H35.35
86. Шар толбоны друз (*Drusen (degenerative) of macula*). H35.36
87. Торлогийн латтис сөнөрөл (*Lattice degeneration of retina*). H35.41
88. Торлогийн нөсөөд дистрофи (*Pigmentary retinal dystrophy*). H35.52
89. Төвийн шүүдэст хориоретинопати (*Central serous chorioretinopathy*). H35.71
90. Өөр бүлэгт ангилсан өвчний үеийн торлогийн эмгэгүүд (*Retinal disorders in diseases classified elsewhere*). H36

Глаукома (Glaucoma). H40-H42

91. Глаукомын сэжиг (*Glaucoma suspect*). H40.0
92. Нүдний гипертензи (*Ocular hypertension*). H40.05
93. Нээлттэй өнцөнт глауком (*Open-angle glaucoma*). H40.1
94. Бага даралттай глауком (*Low-tension glaucoma*). H40.12
95. Нөсөөт глауком (*Pigmentary glaucoma*). H40.13
96. Анхдагч хаалттай өнцөгт глауком (*Primary angle-closure glaucoma*). H40.2

97. Гэмтлийн шалтгаант хоёрдогч глауком (*Glaucoma secondary to eye trauma*). H40.3

98. Үрэвслийн шалтгаант хоёрдогч глауком (*Glaucoma secondary to eye inflammation*). H40.4

Шиллэг бие ба нүдний алимьн эмгэгүүд (*Disorders of vitreous body and globe*). H43-H44

99. Шилэнцэр унжих (*Vitreous prolapse*). H43.0

100. Шилэнцэрийн цус харвалт (*Vitreous hemorrhage*). H43.1

101. Шилэнцэрийн кристаллин хуримтлал (*Crystalline deposits in vitreous body*). H43.2

102. Шар толбо шилэнцэрийн татлага (*Vitreomacular adhesion*). H43.82

103. Идээт эндофтальмит (*Purulent endophthalmitis*). H44.0

104. Цочмог панофтальмит (*Panophthalmitis (acute)*). H44.01

105. Судаслаг бүрхүүлийн симпатик үрэвсэл (*Sympathetic uveitis*). H44.13

106. Миопийн сөнөрөл (*Degenerative myopia*). H44.2

107. Нүдний сидероз (*Siderosis of eye*). H44.32

108. Нүдний гипотони (*Hypotony of eye*). H44.4

109. Абсолют глауком (*Absolute glaucoma*). H44.51

110. Нүдний алимьн хатангир (*Atrophy of globe*). H44.52

111. Лейкокори (*Leucocoria*). H44.53

112. Гемофтальм (*Hemophthalmos*). H44.81

Харааны мэдрэл ба харааны замын эмгэгүүд (*Disorders of optic nerve and visual pathways*). H46-H47

113. Оптик неврит (*Optic neuritis*). H46

114. Нүдгий алимьн арын неврит (*Retrobulbar neuritis*). H46.1

115. Хордлогын оптик невропати (*Toxic optic neuropathy*). H46.3

116. Цус хомсролын невропати (*Ischemic optic neuropathy*). H47.01

117. Харааны мэдрэлийн гипоплази (*Optic nerve hypoplasia*). H47.03

118. Харааны мэдрэлийн хөхлөгийн хаван (*Papilledema*). H47.1

119. Харааны мэдрэлийн хөхлөгийн хатангир (*Optic atrophy*). H47.2

120. Харааны мэдрэлийн хөхлөгийн сэтэрхий (*Coloboma of optic disc*). H47.31

121. Оптик хиазмын эмгэгүүд (*Disorders of optic chiasm*). H47.4

122. Харааны замын бусад эмгэгүүд (*Disorders of other visual pathway*). H47.5

123. Кортикал хараагүйдэл (*Cortical blindness*). H47.61

Нүдний булчин, хос харааны хөдөлгөөн, аккомодаци ба рефракцийн эмгэгүүд (*Disorders of ocular muscles, binocular movement, accommodation and refraction*). H49-H52

124. Саажилтын хялар (*Paralytic strabismus*). H49

125. Нүд бүрэн хөдөлгөөнгүй болох (*Total ophthalmoplegia*). H49.3

126. Эзотропи (*Esotropia*). H50.0

127. Экзотропи (*Exotropia*). H50.1

128. (*Vertical strabismus*). H50.2

129. Дуэн-ы хам шинж (*Duane's syndrome*). H50.81

130. Гиперметропи (*Hypermetropia*). H52.0

131. Миопи (*Myopia*). H52.1
132. Астигматизм (*Astigmatism*). H52.2
133. Анизометропи ба анизокони (*Anisometropia and aniseikonia*). H52.3
134. Пресбиопи (*Presbyopia*). H52.4
135. Аккомодацийн агчил (*Spasm of accommodation*). H52.53

Хараа хямрах ба сохрох (Visual disturbances and blindness). H53-H54

136. Амблиопи (*Amblyopia*). H53.0
137. Хараа түр зуур алдагдах (*Transient visual loss*). H53.12
138. Хараа гэнэт алдагдах (*Sudden visual loss*). H53.13
139. Харааны таагүй байдал (*Visual discomfort*). H53.14
140. Диплопи (*Diplopia*). H53.2
141. Харааны талбайн согор (*Visual field defects*). H53.4
142. Өнгөт харааны хомсдол (*Color vision deficiencies*). H53.5
143. Шөнийн харалган (*Night blindness*). H53.6
144. Сохрол ба сул хараа (*Blindness and low vision*). H54

Нүд ба дайвар эрхтэний бусад эмгэг (Other disorders of eye and adnexa). H55-H57

145. Нистагм (*Nystagmus*). H55.0
146. Анизокори (*Anisocoria*). H57.02
147. Миоз (*Miosis*). H57.03
148. Мидриаз (*Mydriasis*). H57.04
149. Тоник хүүхэн хараа (*Tonic pupil*). H57.05
150. Нүдний өвдөлт (*Ocular pain*). H57.1

5.3.3. Зайлшгүй эзэмших гардан үйлдлийн жагсаалт:

Зовхи, нулимсны тогтолцоо, ухархайн эмгэгүүд

1. Зовхины ирмэгийг хамарсан жижиг урагдалд шархны анхдагч цэгцлэлт хийх;
2. Зовхины хоргүй үүсгэвэрийг авах, эд эс судлалын шинжилгээнд илгээх;
3. Халазион нээх, цэвэрлэх;
4. Зовхи/салст бүрхүүлээс биопси авах;
5. Сормуус буруу ургалтыг (сормуус авах, хөлдөөх эмчилгээ, мэс заслын эмчилгээ) засах;
6. Түр зуурын зовхи хаах (*temporary tarsorrhaphy*) мэс засал эмчилгээ хийх;
7. Зовхи эргүүлэх (*Quickert*) оёдол тавих ажилбарыг хийж гүйцэтгэх;
8. Зовхины гадна сэтэлгээг (*lateral canthotomy/cantholysis*) хийж гүйцэтгэх;
9. Нулимсны сүвийг бөглөх /(түр зуур болон байнгын) эсвэл таг (*plug*) оруулах;
10. Нулимсны замын үндсэн ажилбаруудыг (нулимс дамжуулах замын сорилууд, нулимсны замыг угаах, Jones Dye test 1 ба 2 хийх, нулимсны замыг сэтгүүрдэх, гуурс байрлуулах) гардан хийж гүйцэтгэх;
11. Нулимсны хүүдийн буглааг нээх, урсгуур тавих;
12. Эвисцераци/энуукляци мэс заслуудыг гардан хийж гүйцэтгэх;
13. Птоз засах (*Levator advancement, Frontalis sling*) мэс засал хийх;
14. Зовхи чангалах (*Lateral tarsal strip*) мэс засал хийх;
15. Зовхины гадагш, дотогш эргэлтийг засах;
16. Дакриоцистэктоми, дакриоцисториностоми мэс засал хийх;

17. Хавдрын мэс засал болон биопси авахад өмнөд хэсгийн орбитотоми хийх;
18. Нүдний аяганы доод ханын хугарал засах мэс заслыг гардан хийж гүйцэтгэх;

Эвэрлэг болон нүдний гадаргуугын эмгэг, рефракцын мэс засал

19. Вирус, нян, мөөгөнцөр, шимэгчийн гаралтай нүдний халдварын үед дээж авах (эвэрлэгийг хусах, өсгөвөрлөх) мэс ажилбар хийх;
20. Эвэрлэгийн эпителийн дефектийн үед даралттай боолт, бандаж линз тавих;
21. Салст болон эвэрлэгт шигдсэн гадны биетийг авах;
22. Анхдагч далавч хальсыг авах;
23. Далавч хальсыг аваад салстаар нөхөх мэс засал хийх;
24. Зовхины урагдлыг засах;
25. Эвэрлэгийн хүндрэлтэй урагдлуудыг (одлог хэлбэрийн нэвтэрсэн урагдал-stellate-perforating laceration г.м) засах;
26. Эвэрлэгийн урагдлыг засах, анхдагч цэгцлэлт хийх;
27. Эвэрлэгт цавуу түрхэх;
28. Стромын жижиг мэс ажилбаруудыг хийж гүйцэтгэх;
29. Гадна хэсэгт *tarsorrhaphy* мэс ажилбар хийх;
30. Анхдагч халазион, өвдөгийг нээх, цэвэрлэх;
31. Зовхины үүсгэвэрт энгийн зүслэг хийх, биопси авах;
32. Химийн бодисоор гэмтсэн нүдийг угаах;

Судаслаг бүрхүүлийн эмгэгүүд

33. Өмнөд ба арын увейтийн үед үзлэг хийх (биомикроскопи, склерийг дарж үзлэг хийх, нүдний арын сегментийг өсгөлттэй линзээр шинжлэх, шилэнцэрт эс тодорхойлох, нүдний торлог бүрхүүл, хориойд, парс планаг шинжлэх, үнэлэх)
34. Увейтийн оношилгоонд нэмэлт шинжилгээнүүд хийх заалтыг тодорхойлох (флюоресцейнт ангиографи, хэт авиан шинжилгээ, лабораторийн шинжилгээ, бусад дүрс оношилгооны аргууд);

Болрын эмгэгүүд

35. Болрын мэс заслын талбайг ариутгах, ариун дреп байршуулах, мэдээгүйжүүлэг (хэсгийн, субтеноны, ретробульбар) хийх;
36. Эвэрлэгт хажуугийн (sideport) болон үндсэн (main) зүслэг хийх;
37. Склерт туннель үүсгэх
38. Өмнөд хоргод кохесив ба дисперсив вискоэластик оруулах;
39. Болрын өмнөд капсулыг капсулорексис/капсулотомии аргаар нээх;
40. Гидродиссекци ба гидроделинаци хийх;
41. Болрын цөмийг эргүүлэх
42. Болрын цөмд ховил гаргах, хуваах, факоэмульсжүүлэх;
43. Болрын кортексыг аспирац ирригацийн аргаар соруулж авах;
44. Хиймэл болрыг болрын уутанд суулгах;
45. Эвэрлэгийн шархыг битүүмжлэх, шарх хавагнуулах;
46. Мэс заслын дараа шарханд зөөлөн/ хатуу боолт тавих;
47. Болрын арын капсулын хоёрдогч бүдэгшлийн үед лазер капсулотомии хийх;

Торлог бүрхүүлийн эмгэгүүд

48. Чихрийн шижингийн үеийн шар толбоны хавангийн үед цэгэн/торон лазер хийх;
49. Захын тархмал лазер фотокоагуляци (панретинал) хийх;
50. Торлогийн дан урагдалд лазер ретинопекси хийх;
51. Торлогийн урагдал болон бусад эмгэгүүдэд хөлдөөх эмчилгээ хийх;
52. Эндофтальмитын үед шилэнцрээс сорьц авах, шилэнцэрт антибиотик тарих;
53. Шар толбоны хавангийн эмчилгээнд триамцинолон ацетонидыг тенон бүрхүүл доор тарих;
54. Судасны эндотелийн өсөлтийн факторын эсрэг бэлдмэлийг шилэнцэрт тарих;
55. Витрэктоми болон склер бүслүүрдэх мэс засалд туслахаар оролцох;

Нейро-Офтальмологи

56. Хүүхэн харааны үзлэг хийх;
57. Хүүхэн харааны ханьсах урвалын алдагдлыг тодорхойлох, таних, хэмжих;
58. Харааны талбайн шинжилгээ хийх, үр дүнг унших;
59. Конпрентацын аргаар харааны талбайн үнэлгээ хийх;
60. Автомат периметрийн шинжилгээг хийх, үр дүнг унших;
61. Харааны мэдрэлийн хөхлөгийг шууд, шууд бус, өсгөлттэй офтальмоскопигоор шинжлэх (харааны мэдрэлийн хөхлөгийн хаван, хатангир, нейроретинитийг таних, гэх мэт)
62. Гавал, тархи, нүдний ухархайн дүрс оношилгооны шинжилгээний хариуг оновчтой тайлбарлах;
63. Нүдний хэт авиан шинжилгээ хийх, хариуг тайлбарлах;

Глауком

64. Зайдал (*Seidel test*)-ын аргаар шүүрэл байгаа эсэхийг шалгах;
65. Цочмог нүдний дотоод даралт ихсэлтийн үед эвэрлэгт парацентез хийх;
66. Нээлттэй өнцөгт глаукомын үед сонгомол лазер трабекулопласти хийж гүйцэтгэх;
67. Хаалттай өнцөгт глаукомын үед аргон ба YAG лазер хийж гүйцэтгэх;
68. Хаалттай өнцөгт глаукомын үед захын иридэктоми хийж гүйцэтгэх;
69. Хүүхэн харааны хориггүй хаалттай өнцөгт глаукомын үед захын иридопласти хийж гүйцэтгэх;
70. Лазераар оёдол таслах ажилбар хийж гүйцэтгэх;
71. Циклопеструктив мэс засал (фотокоагуляц эсвэл криотерапи) хийх;
72. Антиметаболиттай ба антиметаболитгүй энгийн ба давтан трабекулэктоми мэс засал хийх;
73. Өмнөд хоргыг мэс заслын аргаар сэргээх;

Хүүхдийн нүд судлал ба хялар

74. Нүдний гадна булчин суллах (*recession*) мэс засал хийх;
75. Нүдний гадна булчин тайрах (*resection*) мэс засал хийх;
76. Нүдний гадна булчингийн хүчийг сулруулах (жишээ нь, тенотоми) ба чангалах (жишээ нь: *tuck*) мэс ажилбаруудыг хийж гүйцэтгэх;

77. Нүдний гадна булчингийн байрлалыг өөрчлөх (*transposition*)
78. Нүдний гадна булчинд зохицуулах оёдол тавих;
79. Мэс заслын үед булчингийн үйл ажиллагааг шалгах (Forced duction test) сорилыг хийж гүйцэтгэх;
80. Хамар нулимсны сувгийн бөглөрөлийг эмчлэх, нулимсны сувгийг сэтгүүрдэх;
81. Халазионыг мэс заслын аргаар эмчлэх;
82. Контагиозный моллюскийг мэс заслын аргаар эмчлэх;
83. Хяларын мэс заслын хүндрэлийг (жишээ нь булчин алдах, өмнөд хэсгийн ишеми, overcorrection, undercorrection) мэс заслын аргаар засах;

Оптик

84. Шууд офтальмоскопи хийх;
85. Шууд бус офтальмоскопи хийх;
86. Ретиноскопи хийх;
87. Энгийн томруулдаг шил (томруулагч) ашиглах;
88. Лензметр ашиглах;
89. Боломжит харааны чадал хэмжигч ашиглах;
90. Мэс заслын микроскопи ашиглах;
91. Эвэрлэгийн пахиметри ашиглах;
92. Лее дэлгэц, Хесс хүснэгт ашиглах;
93. Синоптофори ашиглах;
94. Нүдний угийг линзээр шинжлэх (панфундускопи, Голдман линз, Хруби линз, 90 диоптри)
95. Өнгөний тест (Ишихара тест, Харди Ланд Риттлер тест, Фарнворт Мунсел тест) ашиглах;

Нүдний гистопатологи

96. Нүдний эмгэг судлалын лабораторид бүх төрлийн сорьцыг боловсруулах;
97. Тусгай будагч бодисоор будсан эсвэл судалгааны зориулалттай сорьцтой тусгайлан ажиллах;
98. Нүдний алимьг зүсэж шинжлэх;
99. Нүдний өвчний идэвхитэй үед авсан сорьцод хийж буй микроскопийн шинжилгээнд эмгэг судлаач эмчийн хяналт, удирдлага дор туслан оролцох;

Нүдний хавдар судлал

100. Нүдэн доторх хавдрын үед нүдний ханыг нэвт гэрэлтүүлэх аргыг хийж гүйцэтгэх;
101. Энукляци хийх;

Сул харааны сэргээн засалт

102. Өвчтөнд зориулсан оновчтой нөхөн сэргээх эмчилгээ ба оптик багажийг сонгон эмчилгээний үр дүнд хүрэх;
103. Гемиянопси талбай алдагдлын үед харааны талбайг сайжруулах арга техникийг эзэмших;
104. Сул хараатай хүний жолоодох эрхэд үнэлгээ хийх;

105. Харааны өөрчлөлтийг үнэлэхийн тулд харааны чадал ба харааны талбайг тодорхойлох (хууль эрх зүй ба даатгал);
106. Сул хараатай өвчтөнд боловсрол олгох, багаж, хэрэгслийг хэрэглэх болон хязгаарлалтыг тодорхойлох;

ЗУРГАА. СУРГАЛТЫН АГУУЛГА

Нүд судлал үндсэн мэргэшлийн сургалт нь суралцагч төвтэй байх бөгөөд суралцагч, сургалт удирдах багш, эмнэл зүйн сургагч багш, сургалт эрхлэх үндсэн байгууллага, эрүүл мэндийн бусад сүлжээ байгууллагууд, эрүүл мэндийн бусад ажилтан, үйлчлүүлэгч/өвчтөн, түүний гэр бүлийн хамтын ажиллагаанд суурилна.

6.1. Суралцагчдад тухайн сургалт эрхлэх байгууллагаас дор дурдсан агуулгатай, нэгээс доошгүй хоногийн хугацаатай чиглүүлэх сургалтыг зохион байгуулна. Үүнд:

- Сургалт эрхлэх байгууллагын танилцуулга (эмнэл зүйн мэргэшүүлэх сургалтын хувьд сүлжээнд нэгдсэн бусад байгууллагын танилцуулга);
- Сургалт удирдах чиглүүлэгч болон эмнэл зүйн сургагч багшийн бүрэлдэхүүн;
- Сургалтын зорилго, хөтөлбөр, төлөвлөлт, хяналт, үнэлгээ хийх арга зүй;
- Сургалт/тойролт хийх тухайн байгууллагад мөрдөх дүрэм, журам, заавар, стандарт;

6.2. Чиглүүлэх сургалтыг сургалт хариуцсан байгууллагын чиглүүлэгч багш, эмнэл зүйн сургагч багш, эмч, мэргэжилтнүүд хариуцан зохион байгуулж үр дүнг сурлагын дэвтэрт тэмдэглэнэ.

6.3. Заавал суралцах эмнэлзүйн бус тойролтууд нь 1 дүгээр дамжаанд 1-2 долоо хоног, 2 дугаар дамжаанд 2 долоо хоног, 3 дугаар дамжаанд 1 долоо хоног тус тус байхаар тусгагдсан бөгөөд сонгон судлах эмнэлзүйн бус тойролтыг 3 дугаар дамжаанд сонгон суралцаж үр дүнг тооцуулсан байна.

6.4. Эмнэлзүйн мэргэшүүлэх тойролт хийх нийт хугацаа 116 долоо хоног байх ба 11 сэдэвчилсэн чиглэлээр 1 дүгээр дамжаанд 38 долоо хоног, 2 дугаар дамжаанд 38 долоо хоног, 3 дугаар дамжаанд 40 долоо хоног тус тус байна.

Тойролтын агуулга, хугацаа

№	Тойролтын нэр	Хугацаа
Заавал судлах		
1	Нүд судлалын үндэс: Нүд судлалын шинжлэх ухаан, Харах эрхтний хөгжил, анатоми, физиологийн онцлог	2 долоо хоног
2	Нүд судлалын ёс зүй (<i>Ethics in Ophthalmology</i>)	2 долоо хоног
3	Халдварын сэргийлэлт, хяналт	3 долоо хоног
4	Яаралтай болон амилуулах суурь тусламж	3 долоо хоног
5	Оптик, Рефракци, Контакт линз	12 долоо хоног
6	Зовхи, нулимсны тогтолцоо, ухархайн эмгэг	12 долоо хоног

7	Эвэрлэг ба нүдний гадаргын эмгэг, рефракцийн мэс засал	12 долоо хоног
8	Судаслаг бүрхүүлийн эмгэг	12 долоо хоног
9	Болорын эмгэг	12 долоо хоног
10	Торлог бүрхүүлийн эмгэгүүд	12 долоо хоног
11	Нейро-Офтальмологи	12 долоо хоног
12	Глауком	12 долоо хоног
13	Хүүхдийн нүд судлал ба хялар	12 долоо хоног
14	Нүдний хавдар	4 долоо хоног
15	Сул харааны сэргээн засалт	4 долоо хоног
Сонгон судлах		
16	Нүдний эмгэг судлал (<i>Ophthalmic Pathology</i>)	2 долоо хоног
17	Судалгааны арга зүй (<i>Research methodology</i>)	2 долоо хоног
18	Хууль эрх зүй (<i>Legal Law</i>)	2 долоо хоног

Тойролт 1. Нүд судлалын үндэс

1. Нүд судлалын шинжлэх ухааны суурь ойлголтууд
2. Харах эрхтний хөгжил, анатоми, физиологи
3. Нүд шинжлэх арга, нүдний үзлэг
4. Харааны анализаторын үйл, түүнийг шинжлэх арга

Тойролт 2. Нүд судлалын ёс зүй (Ethics in Ophthalmology)

1. Анагаах ухааны ёс зүйд хэрэглэгддэг нэр томъёоны үндсэн ойлголт, тодорхойлолт (ёс суртахуун ба ёс зүй, бие даасан байдал, ашиг тус, хор хөнөөлгүй байдал, үнэнийг хэлдэг, шударга ёс, хариуцлага, энэрэн нигүүлсэх сэтгэл)
2. Анагаах ухааны суурь баримт бичигт заасан ёс зүйн зарчмууд
 - а. Гиппократын тангараг
 - б. Женевийн тунхаглал
3. Нүдний эмчилгээний менежментийн үндэс
4. Нүдний эмнэлзүйн практикт баримтлах ёс зүйн үндсэн зарчмууд
5. Хүнийг хамарсан судалгааны талаар эмнэлгийн баримт бичигт заасан ёс зүйн үндсэн зарчмууд
 - а. Нюрнбургийн код
 - б. Хельсинкийн тунхаглал
 - в. Белмонтын тайлан

Тойролт 3. Халдварын сэргийлэлт, хяналт

1. Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн гарын эрүүл ахуйн мөрдөлт, гар угаах, халдваргүйжүүлэх үйл явц
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд үйлчлүүлэгчийн зөөлөн эд, ясанд нэвтэрдэг, арьс, салстыг гэмтээдэг, цус, био шингэнд хүрэлцдэг давтан хэрэглэгддэг багаж, хэрэгслийн угаалга, халдваргүйжүүлэлт, ариутгах, хадгалах үйл явц
3. Хувийн хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх, тайлах арга, технологи
4. Халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ, сургалт мэдээлэл хүргэх үйл явц
5. Эмнэлгийн дотоод орчны цэвэрлэгээ үйлчилгээнд өдөр тутам хяналт хийх зарчим
6. Эмнэлгийн зөөлөн эдлэл, цагаан хэрэглэл угаах, халдваргүйжүүлэх зарчим
7. Оношилгоо эмчилгээнд хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгслийг угаах, халдваргүйжүүлэх, ариутгах зарчим
8. Нян судлалын шинжилгээнд дүн шинжилгээ хийх, эмнэлгийн дотоод халдвараас урьдчилан сэргийлэх
9. Хурц үзүүр, иртэй багаж хэрэгсэлд өртөх, өртөлтийн дараах арга хэмжээ авах
10. Эмнэлгийн ахуйн болон аюултай хог хаягдлын ангилан ялгалт, цуглуулах, зөөвөрлөх, хадгалах зарчим
11. Эмнэлгийн зөөлөн эдлэл, цагаан хэрэгсэл угаах, халдваргүйжүүлэх зарчим

12. Агаарын халдваргүйтгэл, хуваарийн дагуу шавьж мэрэгчгүйтгэл хийх үйл ажиллагааны зарчим

Тойролт 4. Яаралтай болон амилуулах суурь тусламж

1. Амилуулах суурь тусламж (АСТ)-ийн эмнэлзүйн удирдамжийг мэддэг байх
2. Амилуулах суурь тусламж (АСТ)-ийн гинжин дарааллын ач холбогдлыг мэддэг байх
3. Амь тэнссэн байдлыг таньж мэдэх
4. Зүрх амьсгал зогссоныг тодорхойлох
5. Амьсгалын замыг чөлөөлөх
6. Амилуулах суурь тусламжийг мэргэжлийн түвшинд үзүүлэх чадвар
7. Цээж шахалт, аврах амьсгалуулалт хийх зарчим
8. Аврагчид үүсэх эрсдэл
9. Автомат тохируулгат дефибриллятор хэрэглэх дарааллын алгоритм
10. Амилуулах лавшруулсан тусламжийг эрт эхлүүлэх ач холбогдлыг мэддэг байх

Тойролт 5. Оптик, Рефракци, Контакт линз

Физикийн оптик

- | | |
|--------------------------------|--|
| 1. Гэрлийн хэв шинж | 10. Дамжих болон нэвчих |
| 2. Цахилгаан соронзон спектр | 11. Фотометр |
| 3. Долгионы томъёо | 12. Лазерууд |
| 4. Фотоны бөөмийн онол | 13. Гэрэлтүүлэг |
| 5. Дифракци | 14. Зургийн санар |
| 6. Интрефренц ба уялдаа холбоо | 15. Цайрал болон туяа |
| 7. Тодрол | 16. Гэрлийн тархалт- Оптик медиа болон хугарлын индекс |
| 8. Туйлшрал | |
| 9. Сарних | |

Геометрийн оптик

- | | |
|--------------------|-------------------------------------|
| 17. Тусгал (толин) | 21. Астигматик линз |
| 18. Хугарал | 22. Линзний тэмдэглэгээ |
| 19. Призмүүд | 23. Үл мэдэгдэх линзийг тодорхойлох |
| 20. Сфер шил | 24. Линзний гажиг |

Клиник оптик

- | | |
|--|--|
| 25. Нүдний оптик | 32. Эмметропи |
| 26. Оптик орчноор гэрэл дамжих | 33. Аккомодаци |
| 27. Схемийн болон багасгасан нүд | 34. Пуркнье ээлж |
| 28. Хүүхэн харааны хариу урвал ба оптик системийн нягтралд үзүүлэх нөлөө | 35. Пинхол |
| 29. Харааны чадал | 36. Аметропи |
| 30. Гэрэлд мэдрэг байдал | 37. Аккомодацийн асуудлууд |
| 31. Catoptric зураг | 38. Хугарлын гажгууд |
| | 39. Аметропыг засах |
| | 40. Афаки үеийн шилэнд тулгардаг асуудлууд |

41. Конвергенц болон аккомодацид контакт линз болох шилээр засах нөлөө (далайц, ойр цэг, холын цэг)
42. Линзийн хүчний нөлөө
43. Арын орон зай (BVD)

Клиник рефракци

48. Ретиноскопи
49. Субъектив рефракц
50. BVD хэмжих
51. Булчин тэнцвэржүүлэх сорил
52. Аккомодацийн хүч
53. Хүүхэн хараа хоорондын зай

Багаж болон сорилууд

59. Шууд офтальмоскопи
60. Шууд бус офтальмоскопм
61. Ретиноскопи
62. Фокиметр
63. Энгийн томруулдаг шил (томруулагч)
64. Лензметр
65. Гэрэл ба тодосгогч сорил
66. Боломжит харааны чадал хэмжигч
67. Автомат рефрактометр
68. Биомикроскопи (үзлэг хийх арга багтана)
69. Стерео тест
82. Өнгөний тест (Ишихара тест, Харди Ланд Риттлер тест)
83. Контакт линз зүүх шаардлагатай өвчтөнөөс асуумж цуглуулах, үзлэг болон шинжилгээ хийх талаар анхан шатны мэдлэгтэй байх
84. Контакт линз зүүдэг өвчтөнд ретиноскопи, рефракци болон илүүдсэн-рефракцийн аргуудыг гүйцэтгэх
85. Зөөлөн болон хатуу контакт линз (Хий нэвтрүүлдэг хатуу контакт линз) суурь муруйн өөрчлөлт, контакт линз болон эвэрлэг хоёрын хоорондох нулимсан давхарга зэргийн оптик болон оптикийн бүсийг тайлбарлах
86. Нэмэх цилиндрээс хасах цилиндрүү хөрвүүлэх, харааны шилний жорыг контакт линзний жорруу хөрвүүлэх аргыг тайлбарлах
87. Тохиромжтой нэр томъёо ашиглан контакт линзний үндсэн загварыг тайлбарлах
88. Контакт линз тааруулах үндсэн арга техникийг тайлбарлаж, гүйцэтгэх
89. Энгийн контакт линз хэрэглэх хүмүүсийг зөв ангилах
90. Нэмэлт хэрэгсэл, үзлэгийн аргуудыг ашиглан контакт линз тааруулах
91. Контакт линз хэрэглэхэд зовиургүй байх, нүдэнд тохирсон байх болон контакт линзээр засарсан харааны чадал зэрэгт хяналт тавих
92. Контакт линзний хэрэглээний эсрэг заалтыг тодорхойлох

44. Томруулах нүдний шил
45. Болрын тооцоолол
46. Пресбиопи (ойрын харааг хэмжих)
47. Сул харааны хэрэгсэл

54. Линзийн төвлөрлийг сааруулах, призматик нөлөө
55. Линзний шилдэг төрөл
56. Олон үйлдэлт шилний жор бичих
57. Хүүхдэд жор бичих
58. Циклофлеги рефракц

70. Эвэрлэгийн топографи
71. Аппланацн тонометр
72. Спекюлар микроскопи
73. эс заслын микроскопи
74. Томруулах линзний зарчим
75. Эвэрлэгийн пахиметр
76. Лее дэлгэц, Хесс хүснэгт
77. Синоптофори
78. Нүдний угт хэрэглэгдэх линз (панфундускопи, Голдман линз, 90Д)
79. Нүдний угийн зураг авагч
80. Гониоскопи
81. Тонометр

93. Контакт линзний оптик болон үндсэн суурь ойлголтуудыг тайлбарлах (контакт линзний сонголт, хувь хүнд тохируулах арга барил гэх мэт)
94. Энгийн контакт линз хэрэглэх тохиолдлын заалтыг жагсаан бичих

Тойролт 6. Зовхи, нулимсны тогтолцоо, ухархайн эмгэг

1. Нүдний зовхи, нулимсны тогтолцоо, ухархай ясны анатоми, физиологийн тухай суурь мэдлэгийг эзэмших (зовхи, зовхины цагираг булчин, ухархайн бүтцүүд, мейбомин булчирхай, нулимсны булчихрай, Зейсийн булчирхай, Whitnall-ын холбогч эд, Мюллерийн булчин, Lockwood-ын холбогч эд, нулимсны суваг, нулимсны сүв, ухархай яснууд, ухархайн нүх, хамрын хөндий, шөрмөсөн цагираг буюу annulus of Zinn, артери, венийн судасны цусан хангамж, тунгалгийн зангилаа, мэдрэлжүүлэлт, нүдний гадна булчингууд гэх мэт)
2. Нүдний зовхи, нулимсны тогтолцоо, ухархай ясны гэмтлийн үед авах эмчилгээний үндсэн механизм, зарчмуудыг эзэмших
3. Ургийн архины хам шинж буюу Fetal alcohol syndrome-ын тархвар судлал, эмнэлзүйн шинж тэмдгүүд, үнэлгээ, менежментийн талаар судлах
4. Нийтлэг тохиолддог окулопластикын эмгэгтэй өвчтөнүүдэд мэс заслын өмнөх болон дараах үнэлгээг хийх
5. Нүдний ухархайн энгийн гэмтлийг үнэлэх (ухархайн гадны биет, ретробульбар цус харвалт гэх мэт)
6. Суларсан зовхины хам шинж буюу Floppy eyelid syndrome-ыг үнэлэх, эмчлэх
7. Трихиазыг үнэлэх, эмчлэх
8. Блефароспазм болон hemifacial spasm-нүүрний нэг талын булчингийн спазмыг үнэлэх
9. Хүүхэд болон насанд хүрэгчдэд нийтлэг тохиолддог нүдний ухархайн хавдруудыг ялган оношлох
10. Нулимсны булчирхайн масссыг ялган оношлох (үрэвсэл, хавдар, төрөлхийн, халдварын шалтгаантай гэх мэт)
11. Дүрсийн оношилогоо дээр ухархайн хэвийн анатомийг таньж мэдэх (соронзон резонанс томограф-MRI, компьютер томограф-СТ, эхо гэх мэт)
12. Хүүхэд болон насанд хүрэгчдэд илэрдэг проптозыг ялган оношлох
13. Мэс заслын өрөөний жижиг гардан үйлдлийн техник, хүндрэлийн талаар судлах (халазионы зүслэг, зовхины үүсгэвэр тайрах гэх мэт)
14. Ухархайн зөөлөн эдийн үрэвсэл буюу orbital cellulitis илрэх шинж тэмдгүүдийг таних

Тойролт 7. Эвэрлэг ба нүдний гадаргын эмгэг, рефракци мэс засал

1. Нүдний эвэрлэг, салст, уураглаг бүрхэвч, зовхи, нулимсны аппарат, дайвар эрхтнүүдийн анатоми, үр хөврөл судлал, физиологи, эмгэг судлал, бичил судлал, дархлаа судлал, генетик, тархвар судлал, эм судлалын тухай суурь мэдлэгийг эзэмших
2. Эвэрлэг бүрхэвч, уураглаг бүрхэвч, нүдний алимны төрөлхийн гажгуудын талаар судлах (Петрийн гажиг, микрофтальм, төрөлтийн гэмтэл, буфтальм г.м)
3. Эвэрлэг болон салстын дегенераци өөрчлөлтүүдийн шинж чанарыг судлах (далавчит хальсны ургалт, өөх ургалт, насжилтын шалтгаант склерийн толбо, кератоконус г.м)

4. Нийтлэг тохиолддог эвэрлэгийн дистрофи, дегенераци өөрчлөлтүүдийг судлах (газрын зураг-цэг-хурууны хээн дистрофи- map-dot-fingerprint dystrophy, Meesmann дистрофи, Рейс-Баклерсын дистрофи, Франсуагын хам шинж, Шнайдерийн талст дистрофи, удамшлын шалтгаант төрөлхийн стромын дистрофи, lattice буюу торон бүтцэт дистрофи, гранулар дистрофи, macular буюу толбот дистрофи, удамшлын шалтгаант төрөлхийн эндотелийн дистрофи, Фуксын дистрофи, арын полиморф дистрофи, Зальцманы дегенераци г.м)
5. Нийтлэг тохиолддог үрэвслийн болон халдварын шалтгаант эвэрлэгийн өвчнүүдийн талаар судлах (энгийн герпес, бүслүүр үлд, тэмбүү, завсрын эвэрлэгийн үрэвсэл г.м)
6. Эвэрлэгийн оптик болон рефракцийн үндсэн ойлголтуудыг эзэмших (кератоконус г.м)
7. Нүдний микробиологийн үндсэн ойлголтуудыг эзэмших, үрэвслийн болон халдварын шалтгаант эвэрлэг болон салстын өвчнүүдийн талаар судлах (стафилококкийн хэт мэдрэг байдал, энгийн бичил биетний кератит, трахома, нярайн нүдний үрэвслүүд, herpes zoster нүдний үрэвсэл, энгийн герпесийн кератит, салстын үрэвсэл г.м)
8. Нүдний гадаргуугийн хамгаалах механизм, грамын аргаар будах, нянгийн ангиллын талаар мэдэх; Антибиотикууд: нүд судлалд хэрэглэгддэг антибиотикуудын гол ангилал, хамрах хүрээ түүний үйл ажиллагаан механизм; Вирусууд: ангилал, бүтэц, олшролт, лабораториор илрүүлэх аргууд; Вирусын эсрэг эмүүд: үйлчлэх механизм; Мөөгөнцөр: ангилал, эзэн биед мэдрэмтгий байдлын хүчин зүйлс, мөөгөнцрийн эсрэг эм, үйлчлэх механизм, Токсоплазм, Хламид, Акантамоеба, эвэрлэг болон салстын эмгэг судлалын ойлголтууд, нүдний өсгөврийг тайлбарлах чадваруудыг эзэмших
9. Эвэрлэг авах ажилбар, донор сонголт, эвэрлэг хадгалалтын тухай мэдэх
10. Нүдний харшлын тухай ойлголтуудыг эзэмших (phlyctenules буюу эпителийн доорх үрэвслийн зангилаа, улирлын шалтгаантай илрэх цочмог шинж тэмдгүүд- seasonal hay fever, вернал салстын үрэвсэл, харшлын болон атопик салстын үрэвсэл, аварга хөхлөгт салстын үрэвсэл г.м)
11. Зовхины ирмэгийн өвчнүүдийг таньж, эмчлэх (стафилококкт блефарит, мейбомин булчирхайн дисфункц г.м)
12. Витамин А дутагдал (Битотын толбо, нүд хуурайших, харанхуй орчинд дасахдаа удаан) болон эвэрлэгийн мэдрэлийн эмгэгүүдийн шинж тэмдэг, оношлох, эмчлэх аргыг эзэмших
13. Цочмог болон архаг салстын үрэвслүүдийг “нүд улайх”ялган оношлох (склерит, эписклерит, салстын үрэвсэл, ухархайн целлюлит, гонококк болон хламидын үед илрэх салстын үрэвсэл г.м)
14. Өмнөд сегментийн гэмтэл болон токсик гэмтлийн механизмыг судлах (шүлтлэг бодисоор гэмтэх, зовхины урагдал, ухархайн хугарлууд г.м)
15. Нүдний дархлааны урвалын талаарх ойлголтыг эзэмших, өмнөд сегментийн үрэвслийн үед илрэх гадаад шинж тэмдгийг таньж мэдэх (хурц болон архаг явцтай солонговчийн үрэвсэлтэй холбоотой нүд улайх г.м)
16. Нүдний халдварын эсрэг, үрэвслийн эсрэг, дархлаа зохицуулах эмүүдийн эм судлалын үндсэн зарчмуудыг судлах (кортикостеройд, стеройд бус үрэвслийн эсрэг эмүүд, антибиотикуудын хэрэглэх заалт болон эсрэг заалт г.м)

17. Эвэрлэгийн гэмтэл (нэвтэрсэн, нэвтрээгүй), мэс засал хийх шаардлагатай далавч хальсан ургалт, эвэрлэг болон салстын гадны биетийг таньж мэдэх
18. Corneal exposure – г оношилж эмчлэх (тос, шанаа талд зовхины завсар багасгах оёдол тавих- tarsorrhaphy г.м)
19. Нийтлэг тохиолддог хортой болон хоргүй зовхины өөрчлөлтүүд, зовхи болон салстын пигментэт өөрчлөлтүүдийн тархвар судлал, ялган оношилгоо, үнэлгээ, менежментийн талаарх ойлголтуудыг эзэмших (мэнгэ, меланом, анхдагч, олдмол меланоз г.м)
20. Нийтлэг тохиолддог зовхины буруу байрлалт эмгэгүүд буюу malpositions of the eyelids (блефароптоз, трихиаз, дистихиаз, блефароспазм, зовхи гадагш, дотогш эргэх г.м) мөн түүнтэй холбоотой хоёрдогчоор үүсдэг эвэрлэг болон салстын өвчнүүдийн (ил байснаас үүсэх- exposure кератопати г.м) тархвар судлал, ангилал, эмгэг судлал, мэс заслын заалтыг судлах
21. Химийн түлэгдэлтийн эмчилгээний аргыг эзэмших (хүчин зүйлийн төрлүүд, эмийн эмчилгээ г.м)
22. Гифема болон микрогифема-ын шалтгаан хүчил зүйлийг тодорхойлох
23. Өнгөц цэгчилсэн эвэрлэгийн үрэвслийн - superficial punctate keratitis (нүд хуурайших, Thygeson's superficial punctate keratopathy), блефарит, токсикын, хэт ягаан туяаны фотокератопати, контакт линзтэй холбоотой эвэрлэгийн эмгэгийн шалтгаан болон эмчилгээний аргыг эзэмших
24. Exposure keratopathy болон нүд хуурайшилтын зовиур шинж тэмдэг, шинжилгээ, үнэлгээ, эмчилгээний аргыг эзэмших (Ширмерийн тест г.м)
25. Системийн өвчнүүд (Вилсоны өвчин г.м) болон эмийн нөлөөллийн (Амиодароны шалтгаант хуйларсан кератопати - Amiodarone vortex keratopathy) үед илрэх өмнөд сегментийн өөрчлөлтүүдийг таньж мэдэх
26. Хөгжилтэй холбоотой өмнөд сегментийн бусад гажууд болон аниридиа-г үнэлэх, ялган оношлох (Аксенфельд – Ригер, Петрийн гажигтай холбоотой г.м)
27. Идээт грануломын эмчилгээний аргыг эзэмших

Тойролт 8. Судаслаг бүрхүүлийн эмгэг

1. Увейт болон түүнтэй холбоот өвчнүүдийн үед үйлчлүүлэгчээс өвчний түүх цуглуулах, үзлэг хийх үндсэн зарчим
2. Өмнөд болон хойд увейтийн үеийн эмнэлзүйн шинж тэмдгүүд, ялган оношилгоо
3. Увейтийн ялгаатай хэлбэрүүдийг тайлбарлах
4. Өмнөд увейтийн түгээмэл илрэх эмнэл зүйн шинжүүд, ялган оношилгоо. Үүнд: халдварын шалтгаант (бактерийн, вирусийн шимэгчийн, эгэл биетний), үрэвслийн шалтгаант (жишээлбэл: саркойдоз, HLA-B27 холбоот, Бехчетийн өвчин, Коллаген судасны өвчин), хавдрууд (маскурад хам шинж), мэс заслын дараах, гэмтлийн дараах, Фухын хетерохром увейт, өсвөр насны ревматоид артрит
5. Арын сегментийн увейтийн үеийн эмнэл зүйн түгээмэл шинж тэмдгүүд, ялган оношилгоог тайлбарлах
6. Өмнөд ба хойд сегментийн увейтийн үед үзлэг хийх (биомикроскоп , склерийг дарж үзлэг хийх, хойд сегментийг өсгөлттэй үзэх, шилэнцэрт эс тодорхойлох , торлог хоройд, парс планаг үнэлэх)

7. Увейтийн оношилгоонд нэмэлт шинжилгээнүүдийг захиалах заалтыг тодорхойлох (флюоресцен ангиографи, хэт авиан шинжилгээ, лабораторийн шинжилгээ, дүрс оношилгоо)

Тойролт 9. Болорын эмгэг

1. Болор солих мэс засал болон түүнтэй холбоотой урд сегментийн ажилбаруудын үед үүсэх хагалгааны ба хагалгааны дараах хүндрэлүүдийн үнэлэлт, эмчилгээ, заалтуудыг тайлбарлах
2. Болрын цийлттэй өвчтөнүүдэд хагалгааны өмнөх нүдний бүрэн үзлэгийг хийж гүйцэтгэх
3. Болрын цийлтийн ялган оношлогоог томъёолох, мөн болрын хэвийн ба хэвийн бус байдлыг үнэлэх
4. Болор солих мэс засалд орсон өвчтөнд хамгийн тохиромжтой рефракцийг хийж гүйцэтгэх
5. Болрын цийлттэй өвчтөнүүдтэй харилцах эмнэлзүйн ба ёс зүйн шийдвэр-гаргах арга барилыг хөгжүүлэх, хэрэгжүүлэх
6. Болор солих мэс заслын талаар өвчтөнтэй харилцах харилцааны сайн арга барилыг хөгжүүлэх
7. Ердийн ба ахисан түвшний болор солих мэс засал ба хиймэл болор суурилуулах ажилбаруудыг хийж гүйцэтгэх
8. Болрын цийлтийн үндсэн ба ахисан түвшний эмнэлзүйн болон мэс заслын асуудлуудыг шийдвэрлэх
9. Болор солих мэс заслын хагалгааны үеийн болон хагалгааны дараах хүндрэлүүдийг амжилттай оношлох, шийдвэрлэх
10. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багт гар бие оролцон үр дүнтэй ажиллах
11. Бага курсын дадлагажигч нар ба оюутнуудад болрын цийлтийн талаар сургах, зааварлах ур чадвараа хөгжүүлэх
12. Кортикостероид, антибиотик ба мэдээ алдуулалт хийх зорилготой хэсэг газрын тарилгыг хийж гүйцэтгэх
13. Болор солих мэс засалд бэлтгэх суурь алхмуудыг гүйцэтгэх (ж.бэл, зөвшөөрлийн хуудас зуруулах, багаж хэрэгслүүдийг бэлтгэх, мэс заслын ариутгал халдваргүйжүүлэлт, мэс заслын бээлий, нөмрөг өмсөх, ариутгасан даавууг байрлуулах, мөн бусад хагалгааны өмнөх бэлтгэлүүд)
14. Болор солих үндсэн мэс заслын үед хагалгааны микроскопи ажиллуулах техникт суралцах
15. Хагалгааны өрөөнд хяналтан дор экстракапсуляр мэс засал, жижиг зүслэгт болрын мэс засал зэргийг хийж гүйцэтгэх, дараах ур чадваруудыг эзэмших

Тойролт 10. Торлог бүрхүүлийн эмгэгүүд

1. Торлог бүрхүүлийн анатоми ба физиологийн үндсэн зарчмуудыг тайлбарлах (торлог бүрхүүлийн давхаргууд, торлогийн физиологи)
2. Торлогийн судасны өвчнүүдийн үед флюоресцейн ангиографи шинжилгээ хийх суурь ойлголтуудыг тайлбарлах, хэрэгжүүлэх (ж.бэл, ангиографийн заалт, үе шатууд)
3. Торлог ховхролын шалтгаан ба механизмыг тодорхойлох

4. Шар толбоны анатоми, үйл ажиллагаа болон нийтлэг тохиолдох шар толбоны өвчний ерөнхий шинжүүдийг тайлбарлах (ж.бэл, насжилтын-шалтгаант шар толбоны сөнөрөл [age-related macular degeneration-ARMD], шар толбоны цоорол, шар толбоны дистрофи өөрчлөлт, шар толбон дээрх эмгэг хальс-macular pucker)
5. Лазер фотокоагуляцийн үндсэн зарчмуудыг тайлбарлах
6. Торлогийн доргилт, гэмтлийн шалтгаант хоройдын урагдал ба Пурчерийн ретинопати зэрэг өвчнүүдийн шинжийг тайлбарлах, ялган таних
7. Торлогийн судасны өвчнүүдийн түгээмэл хэлбэрүүдийг тайлбарлах (ж бэл, торлогийн вен, артерийн төвийн, хагас-, эсвэл салааны бөглөрөл)
8. Ретинитис пигментоса өвчний нийтлэг шинжүүдийг тайлбарлах
9. Арын шилэнцрийн ховхрол ба торлогийн ховхрол өвчний шинжүүдийг таних, үнэлэх, тайлбарлах.
10. Шууд офтальмоскопи шинжилгээг хийж гүйцэтгэх
11. Шууд бус офтальмоскопи шинжилгээг хийж гүйцэтгэх
12. +78-Д, +90-Д-н линз, гурван-тольт контакт линз эсвэл бусад контакт линзүүд ашиглан завсарт-гэрлийн микроскопиор үзлэг хийх
13. Торлогийн нийтлэг эмгэгүүдийн үед флюоресцейн ангиографи шинжилгээгээр илрэх суурь үзүүлэлтүүдийг тайлбарлах
14. Лазер фотокоагуляцийн заалт, хүндрэлүүдийг тайлбарлах
15. Торлогийн өвчний томоохон судалгаануудын үр дүнг тайлбарлах, үүнд:
 - Чихрийн шижингийн Ретинопатийн Судалгаа (Diabetic Retinopathy Study-DRS)
 - Чихрийн шижингийн Витректомийн Судалгаа (Diabetic Vitrectomy Study-DVS)
 - Чихрийн шижингийн Ретинопатийн Эрт үеийн Эмчилгээний Судалгаа (Early Treatment of DRS-ETDRS)
 - Шар толбоны Фотокоагуляцийн Судалгаа (Macular Photocoagulation Study-MPS)
 - Чихрийн шижингийн Хяналт ба Хүндрэлийн Туршилт (Diabetes Control and Complications Trial-DCCT)
 - Салаа Вений Бөглөрөлийн Судалгаа (Branch Vein Occlusion Study-BVOS)
 - Төвийн Вений Бөглөрөлийн Судалгаа (Central Vein Occlusion Study-CVOS)
 - Нэгдсэн Вант Улсын Чихрийн шижингийн Таамаглал Судалгаа (United Kingdom Prospective Diabetes Study-UKPDS)
 - Насжилтын шалтгаант Нүдний Өвчний Судалгаа (Age-Related Eye Disease Study)

Тойролт 11. Нейро-Офтальмологи

1. Харааны мэдрэлийн замын нейро-анатомийг тайлбарлах
2. Гавал тархины мэдрэлийн нейро-анатомийг тайлбарлах
3. Хүүхэн харааны урвал аккомодацийн нейро-анатомийг тайлбарлах
4. Нүдний хөдөлгөөн, түүнтэй холбоотой нейроны замыг тайлбарлах
5. Түгээмэл тохиолдох харааны мэдрэлийн эмгэгүүдийн үед илрэх шинж тэмдгүүдийг тодорхойлох, үнэлэх, эмчлэх (харааны мэдрэлийн

- миеленгүйжих үрэвсэл, цус хомсролын шалтгаант харааны мэдрэлийн эмгэг, артритийн болон артритийн бус, хордлогын эсвэл тэжээлийн дутагдлын шалтгаант харааны мэдрэлийн эмгэг, Либерийн удамшлын харааны мэдрэлийн эмгэг, этанбутолийн хордлого, нейроретинит, дарагдлын, үрэвслийн, гэмтлийн шалтгаант харааны мэдрэлийн эмгэгүүд)
6. Нүд хөдөлгөгч мэдрэлийн түгээмэл тохиолдох эмгэгүүдийн шинж тэмдгүүдийг таних, үнэлэх, эмчлэх (гурав, дөрөв, зургаадугаар хос мэдрэлийн саажил)
 7. Ухархайн дээд заадас, шүүрэн хөндийн хам шинжүүдийн үед илрэх шинж тэмдгүүдийг тайлбарлах (халдварын, судасны, хавдар, үрэвслийн шалтгаант)
 8. Нистагмийн түгээмэл шалтгаануудыг тодорхойлох, үнэлгээ, менежмент (төрөлхийн хөдөлгөөний болон мэдрэхүйн, доош чиглэлтэй, дээш чиглэлтэй, байрлалаас хамаарах, эмийн шалтгаант)
 9. Хүүхэн харааны түгээмэл тохиолдох өөрчлөлтүүдийг таних, үнэлэх (RAPD, анизокориа, Хорнерын хам шинж, гуравдугаар мэдрэлийн саа, Адиегийн тонуст хүүхэн хараа)
 10. Хамгийн түгээмэл тохиолдох харааны талбайн алдагдлын сонгомол илрэлүүд, үнэлгээ, менежментийг тайлбарлах (харааны мэдрэл, харааны зөрлөг, харааны цацраг, харааны мэдрэлийн төв)
 11. Нүдний Миастени Гревисийн, эмнэлзүйн шинж тэмдэг, үнэлгээ, менежментийг тайлбарлах
 12. Каротид-каверноз фистулийн эмнэлзүйн шинж тэмдэг, үнэлгээ, менежментийг тайлбарлах
 13. Төрөлхийн харааны мэдрэлийн эмгэгүүдийн ялган оношилгоо, үнэлгээ, менежментийг тайлбарлах (Оптик пит, харааны мэдрэлийн колобом, хөхлөг-бөөрний хам шинж, өглөөний алдар хам шинж, хазгай диск, харааны мэдрэлийн гипоплаз, миелинжсэн мэдрэлийн ширхэг, меланоцитом, харааны мэдрэлийн друзен гэх мэт.)

Тойролт 12. Глауком

1. Анхдагч нээлттэй өнцөгт глаукомын (АНӨГ) эпидемиологи, генетикийг тайлбарлах. АНӨГ-ын эмгэг жам, эрсдэлт хүчин зүйл, явц, эмнэлзүйн шинж тэмдэг, менежмент, тавиланг тайлбарлах.
2. АНӨГ-ын үнэлгээ, илрүүлэг хийх
3. Анхдагч хаалттай өнцөгт глауком (АХӨГ)-ын эмгэг жам, эрсдэлт хүчин зүйл, явц, эмнэлзүйн шинж тэмдэг, менежмент, тавиланг тайлбарлах
4. АХӨГ-ын үнэлгээ, илрүүлэг хийх
5. Нүдний дотоод шингэний үүсэлтийн динамик, сромослог бие, өмнөд хорго, өнцгийн бүтцийг тайлбарлах
6. Тонометрийн шинжилгээний үндсэн зарчим, багажийн төрлүүд, тэдний давуу болон сул тал, эмнэлзүйн хэрэглээг тайлбарлах
7. Хэвийн болон глаукоматоз нүдний харааны мэдрэл, торлогийн мэдрэлийн ширхэгийн бүтцийг тайлбарлах. Сонгомол, сонгомол бус глаукомын шалтгаант хонхойлтыг таних

8. Автомат, статик периметрийн үндсэн зарчмийг тайлбарлах. Сонгомол болон сонгомол бус глаукомын үед ахисан түвшний периметрууд, тусгай кинетик периметр, автомат статик периметрийн стратегийг хэрэглэх, тайлбарлах, хариуг унших чадвартай байх
 Гониоскоп, түүний зарчим, гониоскопын линзний төрлүүд, заалт, гониоскоп хийх үндсэн техник, анатомын бүтэц, анхдагч болон хоёрдогч глауком болон нүдний бусад өвчний үед илрэх шинжүүдийг тайлбарлах
 Энгийн глаукомын (АНӨГ, АХӨГ гэх мэт) үед хийх хэсэг газрын болон системийн эмийн эмчилгээний зарчим, заалт, эсрэг заалт, гаж нөлөөг тайлбарлах
 Хэвийн даралтат глаукомын таних, тайлбарлах
 АХӨГ, хоёрдогч өнцөг хаагдалт глауком, хорон глаукомын таних, тайлбарлах
 Гипотоныг таних, эмнэлзүйн шинжүүдийг тайлбарлах (Сейдел тест, салстаас шингэн шүүрэх гэх мэт)
 Глаукомын үндсэн, том судалгаануудын гол үр дүнг нэрлэх (Глаукомын лазерын эмнэлзүйн туршилт судалгаа, Хэвийн даралтат глаукомын судалгаа, Глаукомын ахисан түвшний эмчилгээ гэх мэт)

Тойролт 13. Хүүхдийн нүд судлал ба хялар

1. Хүүхдийн нүдний үзлэгийг хийх онцлогийн талаар мэдлэгтэй болох
2. Харах эрхтэн, төвийн хараа, харааны чадал, түүнийг шалгах аргуудын талаар мэдлэг эзэмших
3. Хүүхдийн сохрол, сул хараанд хүргэдэг нүдний өвчнийг таних мэдлэг олох
4. Нүд улайх, нуухтах, төрөлхийн хамар нулимсны сувгийн бөглөрөлийг оношилох ба эмчлэхэд шаардагдах мэдлэгтэй болох
5. Хүүхдийн нүдний өвчний тусламжийн мэдээллийн сан болон үзлэгийн үр дүнг үзлэгийн хуудасны талаар мэдлэгтэй болох
6. Монгол улсын “Хүүхдийн хараа хамгаалах өдөр” Хүүхдийн нүдний эрүүл мэндийн талаар ард иргэдэд ухуулга сурталчилгааны хэрэгслүүд, арга замын талаар мэдлэг эзэмших
7. Монгол улсын “Зайлсхийж болох сохролыг устгах үндэсний стратеги 2014-2019” хөтөлбөрийн талаар мэдлэгтэй болох ба насанд хүрэгчид, хүүхдийн сохрол, сул хараанд хүргэдэг өвчнүүдийг мэддэг болох
8. Хяларын шинжилгээний үндсэн аргуудыг тайлбарлах (Нэг нүдний хөдөлгөөн ба хоёр нүдний хөдөлгөөн, хаах, үл хаах сорил, ээлжлэн хаах сорил, призм хаах сорил)
9. Хүүхдийн нүдний харааны хөгжил, харааны чадлыг үнэлэх (Center, steady, maintain alignment-тэгш байдлаа хадгалах, E хүснэгт, Аллены дүрс таних хүснэгт, Ландольтын сэтэрхий цагирагт хүснэгт)
10. Хяларын анатоми болон физиологийн талаар тайлбарлах (Нүдний гадна булчингийн мэдрэлжилт, анхдагч үйлчлэл, комитант ба инкомитант хялар, хэт болон сул хариу үйлдэл, хөдөлгөөн хязгаарлагдах болон саккад, pursuit movements)
11. Хоёр нүдний харааны дасан зохицох чадварыг тайлбарлах (Торлогийн хэвийн ба гажгийн нийцэл, хороптер, Панумын талбай, фузи, стерео хараа)

12. Хуурамч хяларыг дүрсэлж тайлбарлах
13. Амблиопын шалтгаануудыг дурдах (үйл ажиллагааны алдагдал, аметропи, хялар, анизометропи, органик)
14. Изотропигийн шалтгаануудыг дурдах (Төрөлхийн, комитант ба инкомитант хялар, дасан зохицлын ба дасан зохицлын бус, декомпенсаци, мэдрэхүйн, мэдрэлийн, миоген, мэдрэл булчингийн холбоо, хязгаарлалт, нистагм блок болох хам шинж, ойрын спазм, нэг нүдний фиксацлах хам шинж, дагах)
15. Экзотропигийн шалтгаануудыг дурдах (Төрөлхийн, комитант ба инкомитант хялар, декомпенсаци, мэдрэхүйн, мэдрэлийн, миоген, мэдрэл булчингийн холбоо, хязгаарлалт, дивергенцийн илүүдэл, экзофориа, конвергенцийн дутагдал)
16. Хяларын хэлбэрүүдийг тодорхойлох (V хэлбэр)
17. Вертикал хяларын шалтгаан, оношилгоо, менежментийг тайлбарлах (мэдрэлийн, миоген, мэдрэл булчингийн холбоо, хөндлөн, вертикал муруйлттай хамааралтай, хязгаарлагдмал)
18. Хяларын мэс заслын бус эмчилгээ дурдах
19. Хүүхдийн нистагмын төрлүүдийг дурдах
20. Дутуу нярайн ретинопатийн онцлог, ангилал болон эмчилгээний заалтыг дурдах
21. Хүүхдийн катарактын шалтгаан болон төрлийг дурдах
22. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн нүдний эмгэгийг тодорхойлж таних (торлогийн цус харвалт) ба хүүхэд хамгааллын үйлчилгээ эсвэл бусад байгууллагад зохих ёсоор хандах
23. Удамшлын болон төрөлхийн нүдний хөдөлгөөн болон зовхины хамшинжийг тайлбарлах (Дуане хамшинж, Маркус Гунны хамшинж, Броун хам шинж)
24. Ретинобластоамын ерөнхий шинжийг тодорхойлох
25. Дислекси эмгэгийн үндсэн чанарыг тодорхойлох
26. Хүүхэд болон нярайн хараа бууралтыг үнэлэх (Ретинопати, удамшлын торлогийн эмгэг, төрөлхийн глауком, улаан бурхан болон Витамин А дутагдал)
27. Нүдний төрөлхийн гажгийг тодорхойлох (микрофтальми, persistent fetal vasculature)
28. Удамшлын болон бодисын солилцооны үе дэх нүдний илрэл
29. Хромсомын гажгийн нүдэнд илрэх эмгэгийг тодорхойлох

Тойролт 14. Нүдний хавдар

1. Нүдний гаднах ба доторх хавдрын ангилал
2. Лейкокорын эмчилгээ, ялган оношилгоо, тархалт зүй талаар тайлбарлах (Жишээ нь үрэвсэл, халдвар, неопластик, Коатын өвчин, шиллэг биед цус харвах, торлог хуурах)
3. Нүдний доторх хавдрын шинж тэмдгийг тодорхойлох (Жишээ нь: ретинобластома, хороид меланома, үсэрхийлэл) болон бусад гэмтлээс ялгах
4. Янз бүрийн нүдний доторх хавдруудын эмчилгээний хувилбаруудыг тодорхойлох
5. Нүдний меланомын хамтарсан судалгаа (COMS)-ын үр дүнг тайлбарлах

6. Ретинобластомын ангилал ба эмчилгээг тодорхойлох
7. Нүдний хавдрын гистологийн бүтэц тайлбарлах
8. Солонговч, сормосгон бие, хороид, торлог, харааны мэдрэлийн хавдрын ялган оношлох (жишээ нь: меланома, ретинобластома, гемангиома, меланоцитома)
9. Түгээмэл нүдний доторх хавдрыг оношилж суралцах (жишээ: үзлэг, дүрслэл, лаборатори, хавдрын лавлагаа)
10. Янз бүрийн нүдний хавдрын явцыг үнэлэх мөн бусад эрхтэн системд нөлөөлж буй тодорхойлох
11. Нүдний доторх хавдартай өвчтөнд завсарт гэрлийн биомикроскопи ба офтальмоскопи, Нүдний ханыг нэвт гэрэлтүүлэх аргыг хийх
12. Нүдний хавдрыг илрүүлж ба урьдчилан оношлох
13. Шууд бус офталмоскопийг ашиглан нүдний доторх хавдрын байрлалыг тодорхойлж оношлох
14. Нүдний доторх хавдрын үед нүдний ханыг нэвт гэрэлтүүлэх аргыг хийж эзэмших
15. Хүүхдүүдэд нүдний доторх хавдрыг ерөнхий мэдээ алдуулалтын дагуу үзлэг хийж оношлох чадварыг эзэмших
16. Нүдний доторх эдийн үүсэлтийн үед эхографи А ба В сканер хийх заалтын тодорхойлох
17. Нүдний доторх хавдрын үед тодосгогч бодистой ангиографийн хийх заалтыг тодорхойлох
18. Нүдний доторх хавдар, эвэрлэг, салстыг устгах буюу тайрч авах заалтыг тодорхойлох
19. Нүдний доторх хавдрын үед лазер фотокоагуляци хийх заалт тодорхойлох
20. Нүдний доторх хавдрын үед транспупилларийн дулааны эмчилгээний заалт ба аргыг тодорхойлох
21. Нүдний доторх хавдрын гистологийн үндсэн өөрчлөлтийг тайлбарлах
22. Мэс засал, эмчилгээ ба хүндрэл зэргийг тодорхойлж, зайлшгүй шаардлагатай тохиолдолд доорх шатны эмчилгээг хийх:
23. Нүдний доторх хавдрын үед туяа эмчилгээ хийх заалт ба хүндрэлийг тодорхойлох (жишээлбэл: туяаны толбоны хэсгийн байршил, гаднах цацраг туяа, цацрагийн ретинопати)
24. Эмчилгээний хувилбарыг өвчтөнд ба түүний гэр бүлд тайлбарлаж, ёс зүй, энэрэнгүй байдлаар ярилцах.

Тойролт 15. Сул харааны сэргээн засалт

1. Сул харааг тодорхойлох аргууд (жишээ: ETDRS хүснэгт, Слоаны хүснэгт)
2. Сул хараатай өвчтөнд нөхөн сэргээх эмчилгээнд нөлөөлөхүйц хавсарсан өвчнийг тодорхойлох
3. Сул харааны олон төрлийн тусламжийг эзэмших
4. Сул харааны оптик багажийг ашиглах
5. Харааны өөрчлөлтөд сэтгэл зүйн ба сэтгэл санаанд анхааралтай хандах
6. Харааны өөрчлөлттэй хүмүүст өдөр тутам тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх

7. Сул хараатай хүнд зориулсан оптик багажууд болон оновчтой сэргээн засах эмчилгээ энгийн байдлаар зөвлөх (жишээ нь: томруулах шил, гэрэлтүүлэг)
8. Харааны системийн өвчин ба эмгэг жамын таларх үр дагаврыг тайлбарлах
9. Гемиианопси талбай алдагдлын үед харааны талбайг сайжруулах арга техникийг эзэмших
10. Контраст тест, холын болон ойрын харааны чадлыг шалгаах аргуудын ялгааг тодорхойлох
11. Сул хараатай хүнд автомашин жолоодох үнэлгээ, нөхцөлийг тайлбарлах
12. Харааны өөрчлөлтийн үед харааны чадал болон харааны талбайд гарах шинж тэмдгийг тодорхойлох
13. Сул хараатай өвчтөнд нөхөн сэргээх эмчилгээнд нөлөөлөхүйц хавсарсан өвчнийг таньж мэдэх
14. Сул хараатай хүнд үзүүлэх эмнэл зүйн тусламж үйлчилгээ, хэрэглэх заалт, хязгаарлалтыг танин мэдэх. (жишээ нь: зурагт ойроос үзэх, томруулагч, томоор хэвлэх, Брайл үсэг, уншигч компьютер)
15. Сул хараанд хэрэглэгдэж буй орчин үеийн багажийг танин мэдэх
16. Өвчтөнд зориулсан оновчтой нөхөн сэргээх эмчилгээ ба оптик багажийг сонгон эмчилгээний үр дүнд хүрэх
17. Гемиианопси талбай алдагдлын үед харааны талбайг сайжруулах арга техникийг эзэмших
18. Сул хараатай хүнд жолоодох эрхэнд үнэлгээ хийх
19. Харааны өөрчлөлтийг үнэлэхийн тулд харааны чадал ба харааны талбайг тодорхойлох (хууль эрх зүй ба даатгал)
20. Сул хараатай өвчтөнд боловсрол олгох ба багажийг хэрэглэх болон хязгаарлалтыг тодорхойлох

Тойролт 16. Нүдний эмгэг судлал (*Ophthalmic Pathology*)

1. Нүдний алимын анатомийн бүтэц, нүдний үндсэн бүтцүүдийн гистологийг тайлбарлах (салст бүрхүүл, склер, эвэрлэг, өмнөд хоргын өнцөг, солонгон бүрхүүл, сормослог бие, болор, шилэнцэр, торлог бүрхүүл, торлогын нөсөөт эпители, судаслаг бүрхүүл, харааны мэдрэл гэх мэт)
2. Нүдний нийтлэг тохиолддог эмгэгийн үеийн эмгэг физиологийн явцыг тайлбарлаж өвчин тус бүрээр гистологийн өөрчлөлтийг тодорхойлох (халдвар, үрэвсэл, төрөлхийн хавдар)
3. Нүд болон түүний дайвар эрхтнүүдийн эмгэгийн үеийн гистологи бүтцийг тодорхойлох (эндофталмит, ретинобластома, хоройдал меланома, нянгийн шалтгаант кератит гэх мэт)
4. Эмгэг судлалын лабораторид нүдний сорьцуудыг боловсруулах (сорьц бэлдэх, боловсруулах гэх мэт), боловсруулалтын үндсэн үе шатуудын талаар тайлбарлах, эдгээр үе шатуудыг эзэмших
5. Тусгай будагч бодисоор будсан эсвэл судалгааны зориулалттай сорьцтой тусгайлан ажиллах талаар эмгэг судлаач эмчтэй холбоотой шаардлагатай чухал мэдээллийг тайлбарлах
6. Нүдний эмгэг судлалын хөлдүү хэсгийн заалтыг тайлбарлах
7. Нүдний алимыг зүсэж үзлэг хийх

8. Нүдний өвчний идэвхтэй үед авсан сорьцод хийж буй микроскопийн шинжилгээнд эмгэг судлаач эмчийн шууд удирдлаган дор оролцох

Тойролт 17. Судалгааны арга зүй (Research methodology)

1. Сэдэв сонгох;
2. Өмнөх судлагдсан байдал ба онол, суурь ухагдахууныг ойлгох;
3. Судалгааны ажлын үндэслэл, дэвшилттэй болон шинэлэг тал, нийгэмд оруулах ач холбогдлыг тайлбарлах;
4. Судалгааны зорилго, зорилтуудыг тодорхойлох;
5. Гарах үр дүнд таамаглал дэвшүүлэх;
6. Судалгааны арга, аргачлалыг сонгох;
7. Судалгааны хязгаарлалтыг тодорхойлох;
8. Үйл явц, үр дүнг боловсруулах;
9. Судалгааны ажлыг дүгнэн нэгтгэх;
10. Судалгааны цаашдын боломжийг тодорхойлох;
11. Эх сурвалжийн зохистой ашиглалт гэх мэт

Тойролт 18. Хууль эрх зүй (Legal Law)

1. Монгол Улсын Хууль тогтоомж, эрхзүйн баримт бичиг:
 - Монгол улсын “Эрүүл мэндийн тухай” хууль
 - Монгол улсын “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай” хууль.
 - Монгол улсын “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай” хууль.
 - Монгол улсын “Зөрчлийн тухай” хууль
 - Зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн оношилгоо эмчилгээний удирдамж.
 - “Зайлсхийж болох сохрол, сул харааны стратеги төлөвлөгөө”
2. Эрүүл Мэндийн Сайдын тушаал, журам, Монгол Улсын стандартууд:
 - “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” Эрүүл мэндийн сайдын А/406 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт. 2019
 - “Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журам” Эрүүл мэндийн сайдын А/226 дугаар тушаалын хавсралт. 2020
 - “Эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх журам” Эрүүл мэндийн сайдын А/813 дугаар тушаалын хавсралт. 2021
 - “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам” Эрүүл мэндийн сайдын А/352 дугаар тушаалын хавсралт. 2022
 - “Эрүүл мэндийн технологи. Эмчилгээ, оношлогооны түгээмэл үйлдлүүд” Монгол Улсын стандарт. MNS 4621:2008
 - “Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” Монгол Улсын стандарт. MNS 5095:2017
 - “Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа” Монгол Улсын стандарт. MNS 6330:2017

Загвар 1.

Ажлын байрны сургалт (On-the-Job Training)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Нүдний үзлэг шинжилгээ хийх	5	1 цаг 7 хоногт 3 удаа	Нүдний үзлэгийн өрөө	Эмчлэгч эмч, өвчний түүх	Эмнэл зүйн сургагч багш
	5	1-2 цаг 7 хоногт 3 удаа	Нүдний үзлэгийн өрөө	Нүдний оношилгооны багажууд	
	5	1 цаг 7 хоногт 3 удаа	Нүдний үзлэгийн өрөө	Нүдний оношилгооны багаж, тоног төхөөрөмж	
Өвчний түүх, анхан шатны маягт хөтлөх	5	2 цаг 7 хоногт 3 удаа	Резидент эмч нарын өрөө	Өвчний түүх маягтууд	Мэргэшигч эмч нар
Мэс засалд туслах эмчээр оролцох	1	2 цаг 7 хоногт 3 удаа	Мэс заслын өрөө	Эмчлэгч эмч эмнэл зүйч эмч нар	Эмнэл зүйн сургагч багш
Мэс заслын дараах үзлэг, хяналт хийх	1	2 цаг 7 хоногт 2 удаа	Стационарт	Эмчлэгч эмч эмнэл зүйч эмч нар	Эмнэл зүйн сургагч багш, лабораторийн техникч
Эмч нарын тойрон үзлэгт оролцох	1	2 цаг 7 хоногт 2 удаа	Стационарт	Эмчлэгч эмч эмнэл зүйч эмч нар	Эмнэл зүйн сургагч багш
Мэдээлэл бэлтгэх, танилцуулах	1	4 цаг Сард 1 удаа	Эмнэлгийн хурлын танхим	Эмнэл зүйч эмч нар	Эмнэл зүйн сургагч багш
Эмнэлзүйн тохиолдол танилцуулах	1	4 цаг Сард 1 удаа	Эмнэлгийн сургалтын танхим	Эмнэл зүйч эмч нар	Эмнэл зүйн сургагч багш

Загвар 2.

Танхимын сургалт (Off-the Job Training)

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	1	Тохиромжтой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернет	Өөрөө, хамтран суралцагч эмч
Лекц	20 хүртэл	7 хоногт 2-3 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд	Эмнэл зүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Журнал клуб	20 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэл зүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Эмнэлзүйч нарын хурал	20 хүртэл	Товлогдсон хугацаанд 1-3 цаг	Хурлын танхим	Тохиолдолын танилцуулга	Эмнэл зүйн сургагч багш

Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
~ 8:30	Нүд судлалын үзлэг шинжилгээ хийх	Эмч нарын ярианд мэдээлэл танилцуулах	Мэс засалд туслах эмчээр оролцох	Мэс засалд туслах эмчээр оролцох	Журнал клуб
9:00-11:00	Өвчний түүх, анхан шатны маягт хөтлөх	Мэс засалд туслах эмчээр оролцох	Өвчний түүх, анхан шатны маягт хөтлөх	Мэс заслын дараах үзлэг, хяналт хийх	Мэс заслын дараах үзлэг, хяналт хийх
11:00-13:00	Нүд судлалын үзлэг шинжилгээ хийх	Мэс заслын дараах үзлэг, хяналт хийх	Өвчний түүх, анхан шатны маягт хөтлөх	Өвчний түүх, анхан шатны маягт хөтлөх	Өвчний түүх, анхан шатны маягт хөтлөх
13:30-14:00	Эмч нарын ярианд мэдээлэл бэлтгэх	Бие даалт	Нүд судлалын үзлэг шинжилгээ хийх	Лекц	Бие даалт
14:00-15:00	Нүд судлалын үзлэг шинжилгээ	Өвчний түүх, анхан шатны маягт хөтлөх	Мэс заслын дараах үзлэг, хяналт хийх	Өвчний түүх, анхан шатны маягт хөтлөх	Өвчний түүх, анхан шатны маягт хөтлөх
15:00-17:00	Бие даалт	Бие даалт	Бие даалт	Бие даалт	Бие даалт

ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

7.1. Суралцагч эмч ба хариуцагч

Сургалтын 3 жилийн хугацаанд суралцагч эмч бүрт хэрхэн ахин дэвшиж байгаа, хэрхэн сайжруулах тухай эргэн зөвлөгөө өгөх, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (*career plan*) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн (*mentor*) цаашид “хариуцагч” гэх)-ийг оноож хуваарилна. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж, эргэн зөвлөгөө авна.

7.2. Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш

Суралцагч эмчийн тойролт бүрт сургалт удирдах эмнэл зүйн сургагч багш оноож хуваарилна:

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.

- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

7.3. Үнэлгээний арга

7.3.1. Төгсөлтийн шалгалт

“Нүд судлал”-ын сургалтын төгсөлтийн шалгалтад тэнцсэн тохиолдолд “Нүдний эмч”-ийн үнэмлэх олгоно.

7.3.2 Явцын үнэлгээ

Явцын үнэлгээг тойролт хийх явцад, тойролт бүрийн дараа хийнэ. Явцын үнэлгээний хувь 80%-иас доошгүй байна. Үнэлгээнд дараах аргуудыг ашиглана.

Ажлын байранд-суурилсан үнэлгээ (*Workplace-based Assessment*)

360 хэмийн үнэлгээ (*360-Degree Assessment*):

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (*professionalism*) болон зохион байгуулагч, манлайлагч (*leader*) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. 1 жилийн сургалтын дунд үе болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэл зүйн сургагч багш, сувилахуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өвчтөн зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас сонгоно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвлөгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Mini-CEX/Эмнэл зүйн дасгал үнэлгээ (*Mini-Clinical Evaluation Exercise*) :

Зайлшгүй таньж мэдэх 22 шинж тэмдгээс тойролт бүрт 5-аас доошгүй шинж тэмдгийг тус бүр 3-аас доошгүй удаа, нийт 15-аас доошгүй удаа үнэлгээ хийнэ. Өөр тойролтонд ижил шинж тэмдгээр үнэлгээ хийсэн ч болно. (Жишээ нь: Дотрын тойролтод халуурах шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийсэн бол хүүхдийн тойролтод ч халуурах шинж тэмдгийг оролцуулан 5 шинж тэмдгээр үнэлгээ хийж болно). Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

Гардан үйлдлийн үр чадварын шууд ажиглалт/DOPS (*Direct Observation of Procedural Skills*):

Зайлшгүй сурах 53 гардан үйлдлээс 41-ээс доошгүйг хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч багш нотолж, баталгаа өгөх хүртэл давтан үнэлгээ хийнэ. Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ

хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө заавал өгнө.

Портфолио үнэлгээ (Portfolio Assessment):

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд суралцсан лекц, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

7.4 Үнэлгээний дүнг хянах

- 36-хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална. Үнэлгээний дүнг суралцагч эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч эмч өөрөө хадгална.
- Портфолиод үнэлгээ, эмнэл зүйн сургагч багштай зөвлөлдсөн асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг сургалтын албанд хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч эмчид зөвлөгөө өгнө.

7.5 Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх

- Тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч эмчийг тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрт хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана.

Шийдвэр гаргах шалгуур нь:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын өдрийн тоо, хүндэтгэх шалтгаантай авах амралтын өдрийн тоог оруулаад сургалтын хугацаанд авах амралтын өдрийн тоог сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 20%-аас хэтрүүлэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
- Зайлшгүй таньж мэдэх шаардлагатай 26 шинж тэмдгээс 1 жилийн турш 18-аас доошгүйг оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь:
 - Хүүхдийн дотрын эмгэгийн тойролт бүрт заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 30-аас доошгүй удаа үзэж, туршлага хуримтлуулсан байна.
 - Хүүхдийн мэс заслын тойролтоор 5-аас доошгүй удаа мэс засалд оролцон мэс заслын дараах үзлэгийг тус бүр 5-аас доошгүй хийж, туршлага хуримтлуулсан байна.
 - Хүүхдийн яаралтай тусламжийн тойролтоор 100 хүртэлх хүүхдэд анхан

- шатны тусламж үзүүлсэн байна.
- Хүүхдийн амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээг 10 хүртэлх хүүхдэд үзүүлсэн байна.
 - Зайлшгүй суралцах 56 гардан үйлдлээс 44-ээс доошгүйг хийж гүйцэтгэн, туршлага хуримтлуулсан байна.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 1 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн төгсгөх талаарх шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнө.

НАЙМ. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

(хөтөлбөрийг нэвтрүүлэх ба хэрэгжүүлэх)

8.1 Сургалтын хяналтын зөвлөл

- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Нүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүд, эмнэлэг хариуцсан дэд захирал (тэнхимийн эрхлэгч), сургалтын албаны дарга, мэргэжилтэн нүд судлалын төрөлжсөн мэргэжлийн тасгийн эрхлэгч, тухайн тойролтын сургалт хариуцагч, сувилахуйн албаны төлөөлөл, эмнэлгийн захиргааны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний байгууллагын даргын шууд удирдлага дор ажиллана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь сар бүр хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

8.2. Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч багшид чиглэсэн сургалт (*Faculty Development*), суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж хэлэлцүүлэн, өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

8.3. Сургалтын танилцуулга (*Orientation*)

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (*Program*) болон хөтөлбөрийн (*Curriculum*) агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага (эмнэлэг, эрүүл мэндийн төв), түүний үйл ажиллагаа, эмчилгээ, оношилгооны аюулгүй байдал, халдвар хамгааллын тухай суралцагч эмчид гүнзгий ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

Үнэлгээ

Энэхүү үнэлгээний зорилго нь Нүд судлалын үндсэн мэргэшлийн эмнэл зүйн сургалт явуулдаг (Үндсэн ба Сүлжээ) эрүүл мэндийн байгууллагуудыг хөгжүүлэх, сайжруулах, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, резидент эмч нарын ажиллан суралцах үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулах, сургалтын явцын үнэлгээний тасралтгүй байдлыг хангахад оршино. Энэхүү үнэлгээ нь суралцагчийн хоцрогдол байгаа эсэхийг тодорхойлох, цаг хугацаанд нь засаж залруулах, гарсан ахиц дэвшлийг хянахын зэрэгцээ байнгын дэмжлэг үзүүлэх үндэс суурь болно.

Үнэлгээг ашиглах заавар

Үнэлгээг бүрэн эхээр нь бөглөнө.

Энэхүү үнэлгээг резидентийн сургалт удирдах багийн гишүүд: тухайлбал, нүд судлалын тасгийн эрхлэгч, клиникийн удирдагч, эмнэл зүйн сургагч багш, ахлах дамжааны резидент эмч хийж гүйцэтгэнэ.

Асуултууд дараах форматтай байна.

- Резидентийн хөтөлбөрт хамаарах хариултыг сонгох, дугуйлах эсвэл тэмдэглэх
- Тийм/үгүй хариулт. Резидентийн хөтөлбөртэй холбоотой тохирох хариултыг дугуйлна.
- 1-4 гэсэн шатлалтай. Нэг асуултад 4 хариулт өгөх асуултууд. Хөтөлбөрийг хамгийн сайн тодорхойлж буй тоог дугуйлна.

Эрхэм зорилго, үр дүн

Амжилттай хөтөлбөр нь сургалтын хөтөлбөрийн үр дүнг зөв тодорхойлсон байх ёстой. Үүнд:

- Резидентийн хөтөлбөрийн эрхэм зорилго юу вэ?
- Резидентүүд төгсөх үедээ онолын хувьд ямар чадамжтай байх ёстой вэ?
- Резидентүүд төгсөх үедээ хандлагын хувьд ямар чадамжтай байх ёстой вэ?
- Резидентүүд төгсөх үедээ ур чадварын хувьд ямар чадамжтай байх ёстой вэ?

Эрүүл Мэндийн Яам, Эмнэлгийн Мэргэжилтний Хөгжлийн Зөвлөл, Нүд судлалын салбар зөвлөлөөс Нүд судлалын үндсэн мэргэшлийн сургалтын нэгдсэн цөм хөтөлбөрийн агуулгад багтсан дараах үндсэн 6 чадамжийг аливаа резидентурын сургалтын хөтөлбөртэй уялдуулахыг зөвлөж байна.

Нүд судлалын үндсэн мэргэшлийн эмнэл зүйн сургалт явуулдаг (Үндсэн ба Сүлжээ) эрүүл мэндийн байгууллагууд суралцагчдыг доорх ур чадвар, чадамжуудыг эзэмших ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа бол өмнөх баганын нүдийг чагтална. Нүд судлалын үндсэн 6 чадамж.

ЧАДАМЖУУД

Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээ ба ажилбарын ур чадвар

- Резидентүүд нүдний эрүүл мэндийн асуудлыг эмчлэх, эрүүл мэндийг дэмжихэд энэрэнгүй, зохистой, үр дүнтэй тусламж үзүүлэх чадвартай байх ёстой.

Анагаах ухааны мэдлэг

- Резидентүүд биоанагаах ухаан, эмнэлзүй, эпидемиологи, нийгэм зан үйлийн шинжлэх ухааны тогтсон, хөгжиж буй мэдлэгийг эзэмших ёстой ба энэ мэдлэгийг үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээнд ашиглах ёстой.

Дадлагад суурилан суралцах, сайжрах

- Резидентүүд үйлчлүүлэгчид үзүүлж буй тусламж үйлчилгээндээ хяналт үнэлгээ хийж, шинжлэх ухаанч нотолгоог судлах, шингээх чадварыг харуулах, өөрийгөө байнга цэгнэн, насан туршдаа суралцах үндсэн дээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй сайжруулах ёстой.

Хүн хоорондын болон харилцааны ур чадвар

- Резидентүүд үйлчлүүлэгч, тэдний гэр бүл, эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй үр дүнтэй мэдээлэл солилцож, хамтран ажиллахад шаардлагатай хүн хоорондын харилцааны ур чадварыг эзэмших ёстой.

Мэргэжлийн ур чадвар

- Резидентүүд мэргэжлийн хариуцлага, ёс зүйн зарчмуудыг баримталж ажиллах амлалтаа биелүүлэх ёстой.

Системд суурилсан дадлага

- Резидентүүд өөрийн орны эрүүл мэндийн системийн тусламж үйлчилгээний тогтолцооны онцлогийг сайтар ойлгон ухамсарлаж, оновчтой тусламж үйлчилгээ, хариу үйлдэл үзүүлэхийн тулд нөөцийг үр дүнтэй ашиглах чадварыг эзэмших ёстой.

Хавсралт 1**360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭ: ХАМТРАГЧ (ХАМТРАН АЖИЛЛАГЧ)**

Резидент эмчийн нэр: _____ Огноо: _____

Үнэлгээ өгөх зааварчилгаа: Дараах шатлалыг ашиглан асуулт тус бүрээр үнэлгээ өгнө үү!

Үргэлж	Ихэнхдээ	Заримдаа	Ховор	Үгүй	Хариулах боломжгүй
5 оноо	4 оноо	3 оноо	2 оноо	0 оноо	0 оноо

Чадамж: Мэргэжлийн ур чадвар

Хандлага	Асуулт	Оноо
Хүндэтгэл, энэрэнгүй байдал, шударга байдал	Резидент эмч нь надтай болон хамт олон, бусад бүх шатны хамтран ажиллагсадтайгаа эелдэг, боловсон, хүндэтгэлтэй ханддаг уу?	
Хүндэтгэл, энэрэнгүй байдал, шударга байдал	Резидент эмч нь үйлчлүүлэгч болон болон тэдний гэр бүлийнхэнд эелдэг, боловсон, хүндэтгэлтэй ханддаг уу; Боловсролын түвшин, яс үндэс, хүйсээс үл хамааран эдгээр бүх бүлэгтэй ажиллахдаа энэрэнгүй, өрөвч сэтгэлээр ханддаг уу?	
Хувийн ашиг сонирхлоос илүү үйлчлүүлэгч болон нийгмийн хэрэгцээнд хариу үйлдэл үзүүлэх	Резидент эмч нь үйлчлүүлэгчийн ашиг сонирхлыг өөрийн ашиг сонирхлоос дээгүүр тавьж, үйлчлүүлэгчийнхээ хэрэгцээг мэдэрч чаддаг уу (жишээлбэл, үйлчлүүлэгчээ хянахад хангалттай цаг зарцуулах; өдрийн аль ч цагт үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээний асуудлаар хэн нэгэнтэй утсаар ярихдаа эелдэг хандах; мэс засал хийлгэх хэрэгцээ шаардлагын талаар тодорхой тайлбарлаж өгөх; өөрийн эго үнэ цэнэ эсвэл мэс засалд оролцох оролцоог нь хязгаарлаж болзошгүй байсан ч үйлчлүүлэгчдээ өөрийн суралцагч болох мөн туршлагын түвшинг тайлбарлах) ?	
Үйлчлүүлэгч, нийгэм, мэргэжлийн өмнө хариуцлага хүлээх	Резидент эмч өгсөн үүрэг даалгавар, ажлыг цаг тухайд нь, бүрэн гүйцэд хийж гүйцэтгэдэг үү (жишээлбэл, үзлэг хяналтын тэмдэглэл нь бүрэн бөгөөд үнэн зөв байх, хуулбарлах эсвэл товчлолтой холбоотой бусад алдаанаас зайлсхийдэг; үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээ, бусад холбогдох ажлуудыг хэн нэгэнд даатгахаас илүүтэйгээр өөрөө гүйцэтгэдэг байх; үйлчлүүлэгчийн мэдээллийг нууцалдаг байх; үйлчлүүлэгчийн тухай эсвэл тэдний өвчний талаар олон нийтэд мэдээлэхгүй байх) ?	
Шилдэг байх мэргэжлийн	Резидент эмч нүдний эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг	

ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх хүсэл эрмэлзэл	сайжруулахыг зорьдог уу; мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлж чаддаг уу (жишээлбэл, уншиж, судалж, мэдсэн зүйлээ практикт сайн ашигладаг, сургалтын үйл явцад оролцож, шинээр суралцсан чадвараа практик дээр бататгах, өөрийн ур чадвар, хандлага, мэдлэгийн талаар эргэлзэж байвал бусдаас тусламж хүсдэг байх) ?	
Эмнэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх эсвэл үзүүлэхгүй байхтай холбоотой ёс зүйн зарчмууд, үйлчлүүлэгчийн мэдээлэл, таниулсан зөвшөөрөл, бизнесийн үйл ажиллагааны нууцлалыг баримталдаг байх	Резидент эмч стресстэй байсан хэдий ч ёс зүйн шударга байдлаа хадгалж чаддаг уу? (жишээлбэл, үйлчлүүлэгчийн мэдээллийг нууцалдаг, тэдний тухай болон өвчний талаар олон нийтэд мэдээлдэггүй байх)	
Үйлчлүүлэгчийн соёл, нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй эсэхэд мэдрэмжтэй хандаж, хариу үйлдэл үзүүлэх чадвар	Резидент эмч нь яс үндэс, нас, хүйс, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага, хөгжлийн бэрхшээлтэй байдал, оюун ухаан, нийгэм-эдийн засгийн олон янз байдлыг хүндэтгэн үздэг үү (жишээлбэл, хүн бүртэй эелдэг, хүндэтгэлтэй харьцдаг; соёлын олон янз байдлыг үл харгалзан, бүх үйлчлүүлэгчиддээ зохистой, хүндэтгэлтэй ханддаг ба нүдний эрүүл мэндийн чанартай тусламж үзүүлэх гол зарчмаа баримталдаг) ?	
Нэмэлт санал дүгнэлт:		

Үнэлгээ өгөх зааварчилгаа: Дараах шатлалыг ашиглан асуулт тус бүрээр үнэлгээ өгнө үү!

Үргэлж	Ихэнхдээ	Заримдаа	Ховор	Үгүй	Хариулах боломжгүй
5 оноо	4 оноо	3 оноо	2 оноо	0 оноо	0 оноо

Чадамж: Хүн хоорондын ба харилцааны ур чадвар

Хандлага	Асуулт	Оноо
Үйлчлүүлэгчийн соёлын онцлогт тохирсон эмчилгээ болон ёс суртахууны зөв харилцааг бий болгох, дэмжих	Резидент эмч нь үйлчлүүлэгчдэд хүндэтгэлтэй ханддаг уу (жишээлбэл, зохистой үг хэллэг хэрэглэдэг, хүндэтгэлтэй ханддаг, зохимжтой хошигнол хэрэглэдэг эсэх) ?	
Хүлээцтэй сонсох, үг хэлэх, тайлбарлах, асуух, бичих ур чадвараа ашиглан мэдээлэл олж авах, мэдээллээр хангах	Резидент эмч нь үр дүнтэй асуулт тавих, сонсох ур чадвараа (жишээлбэл, үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлийнхнийг анхааралтай сонсох цаг гаргах) ашиглан мэдээлэл олж авч чаддаг уу?	
Нийгэм, эдийн засаг, соёлын өргөн хүрээнд үйлчлүүлэгч, түүний гэр бүл, олон нийттэй зүй зохистой харилцах	Резидент эмч нь үйлчлүүлэгч, түүний гэр бүл эсвэл асран хамгаалагчдад үр дүнтэй зөвлөгөө өгдөг үү (жишээлбэл, үйлчлүүлэгчдэд мэдээллийг тайлбарлах; тэдний ойлгож чадах түвшинд тайлбарлаж, зөвлөгөө өгөх; тэдэнд өөрсдийн тусламж үйлчилгээнд оролцох боломж олгох) ?	
Эмч эсвэл бусад эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй зүй зохистой харилцах	Резидент эмч нь үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээний талаар, тэр дундаа өөрийн тусламж үйлчилгээ үзүүлсэн үйлчлүүлэгчийг хүлээлгэн өгөхдөө амаар болон бичгээр үнэн зөв, бүрэн тайлагнадаг уу (жишээлбэл, үзлэгийн тэмдэглэл бүрэн, гаргацтай, ойлгомжтой байх; тусламж үйлчилгээг шилжүүлэх үеийн резидентийн тайлан үнэн зөв бөгөөд ач холбогдолтой байх) ?	
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний баг эсвэл бусад мэргэжлийн бүлэгт	Резидент эмч багийн ажиллагаанд зохих хувь нэмэр оруулдаг уу? (жишээлбэл, залуу хамтран ажиллагсаддаа тусалж, тэднийг чиглүүлдэг; тусламж үйлчилгээний багийн бусад гишүүдийг	

гишүүн эсвэл удирдагчаар үр дүнтэй ажиллах	анхааралтай сонсдог; багийн бусад гишүүдэд үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээнд оролцох боломж олгох талаар тэдний ойлгож чадах түвшинд тайлбарлаж, зөвлөгөө өгдөг.	
Нэмэлт санал дүгнэлт:		

Үнэлгээ өгөх зааварчилгаа: Дараах шатлалыг ашиглан асуулт тус бүрээр үнэлгээ өгнө үү!

Үргэлж	Ихэнхдээ	Заримдаа	Ховор	Үгүй	Хариулах боломжгүй
5 оноо	4 оноо	3 оноо	2 оноо	0 оноо	0 оноо

Чадамж: Системд суурилсан дадад зуршил

Хандлага	Асуулт	Оноо
Тусламж үйлчилгээний чанарыг сурталчлах, системийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцох	Резидент эмч нь үйлчлүүлэгчийн боловсрол, яс үндэс, хүйсээс үл хамааран бүх хүнд зөлдөг, халамжтай, хүндэтгэлтэй ханддаг уу (жишээлбэл, үйлчлүүлэгчийг угтан авах, үдэж өгөх, зөвлөгөөний эхэнд өөрийгөө танилцуулах; тэдэнтэй ярилцах, анхааралтай хүлээцтэй сонсох, компьютерийн дэлгэц рүү байнга хардаггүй; гар утсаа оролддоггүй, зөвлөгөө өгөх үеэр харилцан яриа өрнүүлдэг; хүүхэд, өндөр настантай хүлээцтэй ханддаг байх) ?	
Системийн алдааг олж илрүүлэх, системийн боломжит шийдлүүдийг хэрэгжүүлэхэд оролцох	Резидент эмч нь эрүүл мэндийн тогтолцоонд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, арга хэмжээ авдаг уу (жишээлбэл, үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээг сайжруулах үйл явц, боловсролын хөтөлбөрийн хэлэлцүүлэгт ач холбогдол өгч оролцдог; бүс нутаг, үндэсний эсвэл олон улсын түвшинд өвчтөн эсвэл мэргэжлийг сурталчлах ажилд оролцдог эсэх) ?	

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭ: ХАМТРАН АЖИЛЛАГЧ (СУВИЛАГЧ, ТУСЛАХ АЖИЛТАН ГЭХ МЭТ)

Резидент эмчийн нэр: _____ Огноо: _____

Үнэлгээ өгөх зааварчилгаа: Дараах шатлалыг ашиглан асуулт тус бүрээр үнэлгээ өгнө үү!

Үргэлж	Ихэнхдээ	Заримдаа	Ховор	Үгүй	Хариулах боломжгүй
5 оноо	4 оноо	3 оноо	2 оноо	0 оноо	0 оноо

Хандлага	Асуулт	Оноо
Хүндэтгэл, энэрэнгүй байдал, шударга байдал	Резидент эмч нь надтай болон хамт олон, бусад бүх шатны хамтран ажиллагсадтайгаа эелдэг, боловсон, хүндэтгэлтэй ханддаг уу?	
Хүндэтгэл, энэрэнгүй байдал, шударга байдал	Резидент эмч нь бүх түвшний үйлчлүүлэгчдэд эелдэг, анхаарал халамжтай, хүндэтгэлтэй хандаж, боловсрол, яс үндэс, хүйсээс үл хамааран энэрэнгүй сэтгэлээр ханддаг уу (жишээлбэл, өвчтөнийг угтан авах, үдэх; зөвлөгөөний эхэнд өөрийгөө танилцуулах; тэдэнтэй ярилцах, сонсож байх үедээ харцаар холбогдох, байн байн компьютерийн дэлгэц харахгүй байх, зөвлөгөөний үеэр гар утсаар хувийн дуудлага авахгүй байх, хүүхэд, өндөр настнуудад хүлээцтэй ханддаг) ?	
Хувийн ашиг сонирхлоос илүү үйлчлүүлэгч болон нийгмийн хэрэгцээнд хариу	Резидент эмч нь үйлчлүүлэгчийн хэрэгцээнд мэдрэмжтэй ханддаг уу (жишээлбэл, үйлчлүүлэгчийг шаардлагагүйгээр хүлээлгэдэггүй,	

үйлдэл үзүүлэх	үйлчлүүлэгчийн дуудлагад хариулдаг байх)?	
Үйлчлүүлэгч, нийгэм, мэргэжлийн өмнө хариуцлага хүлээх	Резидент эмч нь өөрийн хязгаарлалтыг ухамсарладаг уу (жишээлбэл, өөрт нь тусламж хэрэгтэй үед тусламж хүсдэг байх), резидент эмч нь алдаа дутагдал эсхүл орхигдуулсан зүйлээ хүлээн зөвшөөрдөг үү (жишээлбэл, алдаа гаргаснаа хүлээн зөвшөөрч, уучлалт гуйх, боломжтой бол алдаагаа засахаар ажилладаг байх) ?	
Эмнэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх эсвэл үзүүлэхгүй байхтай холбоотой ёс зүйн зарчмууд, үйлчлүүлэгчийн мэдээлэл, таниулсан зөвшөөрөл, бизнесийн үйл ажиллагааны нууцлалыг баримталдаг байх	Резидент эмч стресстэй байсан хэдий ч ёс зүйн шударга байдлаа хадгалж чаддаг уу? (жишээлбэл, үйлчлүүлэгчийн мэдээллийг нууцалдаг, тэдний тухай болон өвчний талаар олон нийтэд мэдээлдэггүй байх)	
Үйлчлүүлэгчийн соёл, нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй эсэхэд мэдрэмжтэй хандаж, хариу үйлдэл үзүүлэх чадвар	Резидент эмч нь яс үндэс, нас, хүйс, шашин шүтлэг, бэлгийн чиг хандлага, хөгжлийн бэрхшээлтэй байдал, оюун ухаан, нийгэм-эдийн засгийн олон янз байдлыг хүндэтгэн үздэг үү (жишээлбэл, хүн бүртэй эелдэг, хүндэтгэлтэй харьцдаг, соёлын олон янз байдлыг үл харгалзан, бүх үйлчлүүлэгчиддээ зохистой, хүндэтгэлтэй ханддаг ба нүдний эрүүл мэндийн чанартай тусламж үзүүлэх гол зарчмаа баримталдаг) ?	
Нэмэлт санал дүгнэлт:		

Үнэлгээ өгөх зааварчилгаа: Дараах шатлалыг ашиглан асуулт тус бүрээр үнэлгээ өгнө үү!

Үргэлж	Ихэнхдээ	Заримдаа	Ховор	Үгүй	Хариулах боломжгүй
5 оноо	4 оноо	3 оноо	2 оноо	0 оноо	0 оноо

Чадамж: Хүн хоорондын ба харилцааны ур чадвар		
Хандлага	Асуулт	Оноо
Үйлчлүүлэгчийн соёлын онцлогт тохирсон эмчилгээ болон ёс суртахууны зөв харилцааг бий болгох, дэмжих	Хамтран ажиллагч өвчтөнд мэдээллийг тайлбарлахдаа хангалттай цаг хугацаа зарцуулж, хүчин чармайлт гаргадаг уу? (жишээ нь: өвчтөн болон тэдний ар гэрийнхнийг анхааралтай сонсдог, өвчтөнд өөрсдийнхөө тусламж үйлчилгээнд оролцох боломжийг олгохын тулд тэдэнд ойлгомжтой тайлбарлаж, зөвлөгөө өгөх)	
Хүлээцтэй сонсох, үг хэлэх, тайлбарлах, асуух, бичих ур чадвараа ашиглан мэдээлэл олж авах, мэдээллээр хангах	Резидент эмч танд үүрэг даалгавар өгөхдөө амаар эсвэл бичгээр тодорхой илэрхийлдэг үү?	
Эмч, эрүүл мэндийн салбарын бусад мэргэжилтнүүд, эрүүл мэндийн холбогдох агентлагуудтай үр дүнтэй харилцах	Резидент эмч нь харилцан яриа/харилцааны үеэр, ялангуяа үйлчлүүлэгчтэй холбоотой яриаг анхааралтай сонсдог уу?	
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний баг эсвэл бусад мэргэжлийн бүлэгт гишүүн эсвэл удирдагчаар	Резидент эмч таны үзэл санал бодлыг харгалзан үздэг үү?	

үр дүнтэй ажиллах		
Эмнэлгийн анхан шатны бичиг баримтуудыг цаг тухайд нь, бүрэн, гаргацтай бичих	Резидент эмч эмнэлгийн анхан шатны бичиг баримтуудыг цаг тухайд нь, бүрэн, гаргацтай хөтөлдөг үү?	
Нэмэлт санал дүгнэлт:		

Чадамж: Системд суурилсан дадад зуршил		
Хандлага	Асуулт	Оноо
Системийн алдааг олж илрүүлэх, системийн боломжит шийдлүүдийг хэрэгжүүлэхэд оролцох	Резидент эмч нь эрүүл мэндийн тогтолцоонд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, арга хэмжээ авдаг уу (жишээлбэл, үйлчлүүлэгчийн тусламж үйлчилгээг сайжруулах үйл явц, боловсролын хөтөлбөрийн хэлэлцүүлэгт ач холбогдол өгч оролцдог; бүс нутаг, үндэсний эсвэл олон улсын түвшинд өвчтөн эсвэл мэргэжлийг сурталчлах ажилд оролцдог эсэх) ?	
Тусламж үйлчилгээний чанарыг сурталчлах, системийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцох	Резидент эмч нь системийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэхэд туслах замаар үйлчлүүлэгчдэд чанартай тусламж үзүүлэхийг дэмждэг үү (жишээлбэл, өвчтөнийг тээвэрлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх ажлын зардал, ажлын цагийн хуваарь, гэр бүлийн үүрэг хариуцлагатай холбоотой асуудлыг даван туулахад нь туслахын тулд ажиллах; тусламж үйлчилгээний төлөвлөгөөг дагаж мөрдөхийн ач холбогдлыг өвчтөнд тайлбарлаж, түүнийг дагаж мөрдөхөд өвчтөнд ямар нэгэн санаа зовнил байгаа эсэхийг илрүүлэх, шаардлагатай үед төлөвлөгөөг өөрчлөх; эмчилгээний төлөвлөгөөг зохицуулахын тулд нүдний эмч дотор болон бусад эрүүл мэндийн багийн гишүүдтэй харилцах) ?	

Хавсралт 2

ЯВЦЫН MINI-СЕХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он сар өдөр: _____ / _____ / _____

Суралцагч эмчийн нэр: _____ Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Тасаг, нэгж: _____

Бусад _____ Өвчтөний нас: _____ Өвчтөний хүйс: Эр Эм

Өвчний түүхтэй танилцах Үзлэг, шинжилгээ хийх ур чадвар

Эмнэлзүйн сэтгэлгээ, асуудал шийдэх чадвар Үр дүнтэй зохион байгуулах ур чадвар Хамт олондоо хандаж буй анхаарал, хүнлэг байдал

Сайн талууд	Сайжруулахад зөвлөгөө	чиглэсэн	Бусад санал

Сургалтын тухайн үед суралцагч эмчийг ямар түвшинд байгааг ажигласнаа үнэлнэ үү. Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү: □				Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл
Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	
Өвчний түүх бичилт, эрүүл мэндийн анхан шатны маягт хөтлөлт				
Нүдний багаж, тоног төхөөрөмжтэй ажиллах ур чадвар, дадал				
Шалтгаан, эмгэг жамыг үнэлж дүгнэх ур чадвар				
Ялган оношлох ур чадвар				
Харилцааны ур чадвар, үйлчлүүлэгч болон тэдний гэр бүлтэй харилцах				
Багаар ажиллах ур чадвар				

Үнэлэгчийн гарын үсэг: _____

Суралцагч эмчийн гарын үсэг: _____

Хавсралт 3

“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлт	
Өвчний түүх, асуумж авах	<ul style="list-style-type: none"> • Ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг. • Өвчний карт дээрх оноштой танилцаж үйлчлүүлэгчээс зөв асуумж авах.
Гардан үйлдэл	<ul style="list-style-type: none"> • Шинжилгээг стандартын дагуу хийх дэс дараалал зөв. • Нүд, түүний дайврын эмгэгүүдийн өөрчлөлтүүдийг зөв таньж шалгах чадвартай.
Оношилгоо, эмчилгээний менежмент	<ul style="list-style-type: none"> • Зөв онош тавьдаг. • Ялган оношилгоонд шаардлагатай шинжилгээ, маркерийг зөв төлөвлөж, үр дүнг ашигладаг. • Оношийг стандартын дагуу зөв тавьдаг.
Харилцааны ур чадвар	<ul style="list-style-type: none"> • Үйлчлүүлэгчийг сайн сонсдог. • Үйлчлүүлэгчтэй эелдэг энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг.
Нүд судлалын суурь чадвар	<ul style="list-style-type: none"> • Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог. • Үйлчлүүлэгч болон эмчлэгч эмчийг өвчний онош, түүний зураглалын талаарх үнэн зөв мэдээллээр хангаж чаддаг.

**ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ
(DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Он сар өдөр: _____ / _____ / _____

Резидент эмчийн нэр: _____ Үнэлэгчийн нэр: _____

Сургалт эрхлэх байгууллага: _____ Тасаг, нэгж: _____

Гардан үйлдэл: Хийж буй ажилбар, мэс заслын техниктэй холбоотой үндсэн ойлголтуудыг мэдэж буй байдал Мэс заслын өмнөх бэлтгэл ажил Мэс засал хийх ерөнхий ур чадвар Мэс заслын өмнөх дүгнэлт, мэс заслын явц бичих ур чадвар

Одоог хүртэл суралцагч эмч тухайн гардан үйлдлийг хийсэн бодит тоо _____

Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	Ажиглагдаагүй Үнэлэх боломжгүй
Хийж буй шинжилгээний техник болоод холбогдох ойлголтуудыг мэдэж буй байдал				
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хийдэг.				
Халдваргүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг.				
Арга техникийг чадварлаг гүйцэтгэдэг.				
Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг.				
Багаж хэрэгсэл, материалыг цэвэрлэдэг.				
Шаардлагатай бичиг баримтыг гүйцэд бичдэг.				
Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Үнэлэгчийн гарын үсэг: _____

OSCAR - Нүд судлалын Олон улсын зөвлөл (ICO)-ийн Үнэлгээний рубрик жишээг ашиглах

Хавсралт 5-ыг үнэлэх: 1 – Муу; 2 – Дунд; 3 – Сайн

- Перибулбар блок
- Тусгаарлагч
- Микроскопитой харьцах

- Оёдол тавих
- Склерийг хатгах ба төөнөх
- Хүнд шингэн: зохистой хэрэглэх ба аюулгүй оруулах
- Өмнөд хэсгийн капсулотоми
- Шархыг томруулах
- Цөмийн гидродиссекци
- Цөмийг гаргаж авах
- Шаардлагатай хэмжээний холтсыг усалж ба соруулах техникийн дагуу хийх
- Хиймэл болрыг оруулж эцсийн байрлалд байрлуулах
- Шархыг хаах: оёдол тавих
- Шархыг хаах: оёдол зангидах ба түгжих
- Шархыг хаах: хүнд шингэн авах, шархыг чийгшүүлэх, шархны аюулгүй байдал
- Ажилбарын хурд ба цэгцтэй байдал

Хавсралт 6

Резидентийн танилцуулгад үнэлгээ өгөх. Хавсралт 6-гийн дагуу:

- 0 – Муу; 1 – Дундаж; 2 – Сайн;
- Танилцуулга
- Биеийн хэл
- Дууны өнгө
- Слайдын чанар
- Итгэлтэй байдал
- Тодорхой байдал
- Агуулгын хүрээнд
- Суурь чадвар
- Тодорхойлолт
- Уялдаа хамаарал
- Дэвшилт
- Ном зүй

Хавсралт 7

Нүдний эмнэл зүйн даалгаврын дагуу хэрэглэх үнэлгээ– нийт үнэлгээ 30

Хавсралт 7-гийн дагуу үнэлэх

- 0 – Муу; 1 – Дундаж; 2 – Сайн
- Асуумж авах (дээд оноо 7)
- Зовиур авах чадвар
 - Одоогийн өвчний түүх
 - Муу үр дагавар
 - Өвдөлтийн асуумж
 - Харшил
 - Өвчний түүх
 - Гэр бүл ба нийгмийн байдал

Үзлэг (дээд оноо 7)

- Сайн засрах харааны чадал
- Хершберг тест
- Хөдөлгөөн/Проптозис
- Хүүхэн хараа/хүүхэн хараа ханьсах урвалыг шалгах
- Завсарт гэрлийн биомикроскопи (гониоскопи хийх)
- Нүдний дотоод даралт
- Нүдний уг дурандах

Мэргэжлийн ур чадвар (дээд оноо 6)

- Хүндлэл ба эелдэг байдал
- Өвчтөнд энгийн ойлгомжтой тайлбарлах
- Үр дүнг тайлбарлах
- Онош/явц тайлбарлах
- Төлөвлөгөө ба сонголтыг тайлбарлах
- Өвчтөний асуултанд хариулах

Тохиолдол танилцуулах (дээд оноо 10)

- Товч бөгөөд тодорхой
- Тодорхой баримтууд
- Зөв ялган оношлох
- Зохиомжтой төлөвлөгөө боловсруулах
- Асуултанд хариулах чадвар

Хавсралт 8

OSCE-ийн бүтэц зохион байгуулалт

10 өртөө байна (өртөө болгон 10 оноо). Нийт 100 оноо

Өртөө:

- Багажны өртөө
- Эмнэл зүйн зураглал - өртөө
- Дүрс оношилгоо - өртөө
- Гистологи/микрбиологи - өртөө
- Шалгалтыг амаар авах - өртөө
- Схем – Диплопи/талбай - өртөө
- Тохиолдлын бүдүүвч - өртөө
- Нүдний зураглалын - өртөө
- Рефракцийн - өртөө
- Нүдний эм судлалын - өртөө

Хавсралт 9

Сургалтын хөтөлбөрийг үнэлэх асуумж

1. Танай байгууллагад стандарт сургалт/тойролтын хөтөлбөр байдаг уу?
Тийм эсвэл Үгүй
2. Аль нь сургалт/тойролтын хөтөлбөрийг хамгийн сайн тодорхойлж байна вэ?

1.	2.	3.	4.
----	----	----	----

Тодорхой бичигдсэн сургалт/тойролтын хөтөлбөр байхгүй	Тойролтын сэдвийн жагсаалт тодорхойгүй (жишээ нь: глауком, эвэрлэг гэх мэт ерөнхий ангилалтай), стандарт бус тойролт хийдэг эсвэл лекцийн хуваарь байхгүй	Тойролтын сэдвийн нарийвчилсан жагсаалт бүхий (жишээ нь: хаалттай өнцөгт глауком, эвэрлэгийн дистрофи гэх мэт) стандарт тойролт, лекцийн хуваарь байдаг	Зорилго, зорилт тойролт/лекцийн нарийвчилсан хуваарь бүхий Нүд судлалын Олон улсын Зөвлөл (ICO)-өөс гаргасан эсвэл өөр сургалтын хөтөлбөртэй
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

3. Сургалтын хөтөлбөрт тодорхой мэс засал, мэс ажилбар хийх тохиолдлын хамгийн бага тоог заасан байдаг ба үүнийг бүх резидентүүд хангадаг уу?

1. Хамгийн бага тогтоосон тоо байхгүй.	2. Хамгийн бага тоог тогтоосон хэдий ч бүх резидентүүд түүнийг гүйцэтгэх боломжгүй.	3. Тийм, хамгийн бага тоог бүх резидентүүдэд ангиллын 50%-д (катаракт, глаукома, хялар гэх мэт*) тус тус тогтоож, хангасан.	4. Тиймээ, өгөгдөлтэй бүх ангилалд* резидентийн хамгийн бага тоогоор тогтоосон.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

*Катаракт, глауком трабекулэктоми, хялар засах мэс засал, зовхины мэс засал, эвисцераци, энукляци хийх, торлог бүрхүүлийн лазер эмчилгээ, глаукомын лазер эмчилгээ.

4. Дадлагажигч сонгон шалгаруулан авахад албан ёсны процесс (боловсруулалт), сонгон шалгаруулах тодорхой критери буюу шалгуур байдаг уу?

1. Албан ёсны боловсруулалтгүй.	2. Албан ёсны боловсруулалттай боловч хэрэгждэггүй.	3. Албан ёсны боловсруулалтыг ашигласан боловч сонгон шалгаруулах шалгуурыг нарийвчлан заагаагүй.	4. Сонгон шалгаруулалтын нарийвчилсан шалгуур бүхий албан ёсны боловсруулалтаар хэрэгждэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

5. Тухайн клиникт суралцаж буй резидентүүдийн хяналт/шууд ажиглалт болон дадлагажих байдлаар нь хангалттай хэмжээнд суралцаж чаддаг уу?

1.	2.	3.	4.
----	----	----	----

Хяналтгүй.	Заримдаа хяналттай.	Резидентүүд ихэвчлэн хяналттай.	Байнгын зохицтой хяналттай.Тухайн сургалтын клиникт тохиолдлуудыг хянах мөн зөв менежментээр хангах, резидентийн үнэлгээний хэрэгслийг хянах, үйл ажиллагааны тэмдэглэлийг хянах чадвартай зөвлөх нүдний эмч байдаг.
------------	---------------------	---------------------------------	--

¹ Сургалтын үйл явц нь чадварт суурилсан чадамжийг хангасан эсэхийг баталгаажуулах практик эмнэлзүйн ажил, холбогдох онолыг багтаасан байх ёстой. Сэдвүүдийг дурьдахад; катаракт, контакт линз, нүдний эвэрлэг ба өмнөд хоргын өвчин, зовхи болон нулимсны сувгийн эмгэг, глаукома, нейроофтальмологи, нүдний гэмтэл, оптик ба ерөнхий рефракци, ухархайн өвчин ба окулопластик, эмгэг судлал, хүүхдийн нүдний эмгэг, хялар, системийн өвчний зөвлөгөө, увеит, сул хараа болон хугарлын мэс засал, нүдний торлог бүрхүүл-шилэнцрийн эмгэг. Хөтөлбөрт харилцааны ур чадвар, эмнэлгийн ёс зүй, нийгмийн эрүүл мэнд, өвчтөний аюулгүй байдлын талаархи зааварчилгааг багтаасан байх ёстой.

6. Мэс заслын өрөөнд резидентүүдэд зориулагдсан зохих хяналт, шууд ажиглалт, сургалт байдаг уу? Резидентүүд зөвлөх эмчгүйгээр эсвэх ахлах(сениор) резидентийн хяналтгүйгээр мэс засал хийдэг үү?

1. Тодорхой бичигдсэн сургалтын хөтөлбөргүй.	2. Резидентүүд ихэвчлэн бие даан ажилладаг.	3. Резидентүүд ихэвчлэн хяналтан дор ажилладаг	4. Байнгын зохицтой хяналттай ажилладаг.
--	---	--	--

7. Резидентийн мэдлэг, ур чадварыг сургалтын явцад тодорхой хугацаанд үнэлж дүгнэх албан ёсны тогтоц байдаг уу?

1. Тодорхойгүй.	2. Цөөхөн ахиц дэвшлийн тухай үечилсэн үнэлгээтэй	3. Ахиц дэвшлийн үнэлгээг дор хаяж 6 сар тутамд хийдэг.	4. Ашигласан үе шатууд ба үнэлгээг дор хаяж зургаан сар тутамд хийдэг (Хавсралт А-г үзнэ үү)
-----------------	---	---	--

8. Судалгаа нь резидентүүдийн сургалтын хөтөлбөрт хамрагдсан уу (эмнэлзүйн болон суурь шинжлэх ухааны ажлыг багтааж болно)?

<p>1. Хөтөлбөрт судалгаа оруулаагүй болно.</p> <p style="text-align: center;"><input type="checkbox"/></p>	<p>2. Резидентүүдийн цөөнх судалгаа хийдэг. Нийтлэх(нийтлэлд гаргах) оролдлого байхгүй. Судалгааны дотоод болон гадаад танилцуулгагүй.</p> <p style="text-align: center;"><input type="checkbox"/></p>	<p>3. Ихэнх резидентүүдийн хийсэн судалгаа. Нийтлэх оролдлого байна (сэтгүүлд оруулах) Судалгааны дотоод танилцуулгатай.</p> <p style="text-align: center;"><input type="checkbox"/></p>	<p>4. Судалгаа нь бүх резидент хөтөлбөрт суралцагчдын төгсөх хөтөлбөрийн нэг хэсэг болох шаардлага юм Резидент хөтөлбөрт суралцагчдын ихэнх эсвэл бүгд судалгаагаа хэвлэн нийтлэх эсвэл нийтлэхийг оролддог (сэтгүүлд илгээх). Резидент хөтөлбөрт суралцагчид судалгаагаа тогтмол танилцуулдаг (дотоод болон гадаад).</p> <p style="text-align: center;"><input type="checkbox"/></p>
--	--	--	---

9. Резидент хөтөлбөрт суралцагчид бүрт адил тэгш боловсрол олгох төлөвлөгөө бий юу? Үүнийг хэрхэн хэрэгжүүлж байгаа вэ мөн шалгалтанд тэнцэх эсэхийг тодорхойлох ямар өгөгдөл байгаа вэ (бүртгэлийн дэвтэр, ээлжийн хуваарь)?

<p>1. Боловсролын эквивалент олгох төлөвлөгөө байхгүй.</p> <p style="text-align: center;"><input type="checkbox"/></p>	<p>2. Боловсролын эквивалент олгох төлөвлөгөө гаргасан боловч хэрэгжээгүй.</p> <p style="text-align: center;"><input type="checkbox"/></p>	<p>3. Боловсролын эквивалент олгох төлөвлөгөө хэрэгжиж эхэлсэн боловч баталгаажуулах мэдээлэл байхгүй.</p> <p style="text-align: center;"><input type="checkbox"/></p>	<p>4. Дүйцсэн боловсролын төлөвлөгөө , хэрэгжиж буй боловсролын эквивалент(жишээ нь ээлжийн хуваарь, мэс заслын болон эмнэлзүйн тоо)</p> <p style="text-align: center;"><input type="checkbox"/></p>
--	--	--	--

² Эквивалент гэдэг нь резидент хөтөлбөрт суралцагчид бүр тойролтын хугацаанд үзсэн эмгэгийн хэмжээ, хийсэн ажилбарын төрөл, тооны хувьд ерөнхийдөө ижил туршлагатай болно гэсэн үг юм. Жишээлбэл, резидент хөтөлбөрт суралцагчид бүр ижил тойролт хийдэг (эсвэл өөр сонголттой байдаг уу?), мөн ойролцоогоор ижил тооны мэс засал хийдэг үү?

Хавсралт 10

Суралцагчид ба багш нар

1. Дадлагажсан суралцагчдыг тоон үзүүлэлтээр нь сургалтын байгуулагын клиник/практик мэдлэгийн харьцаа, хяналтын чадавхи, нөөцтэй харьцуулан дүгнэхэд пропорциональ буюу ижилхэн байна.

<p>1. Багш нараас дадлагажигчид их Дадлагажигчдын тоон үзүүлэлтэнд хангалттай нөөцгүй Дадлагажигчдын тоонд мэс заслын/эмнэлзүйн хэмжээ хангалтгүй.</p>	<p>2. Багш нараас дадлагажигчид их Дадлагажигчдын тоонд хангалттай нөөцтэй Дадлагажигчдын тоонд мэс заслын/эмнэлзүйн хэмжээ хангалтгүй</p>	<p>3. Багш нараас дадлагажигчид их Дадлагажигчдын тоонд хангалттай нөөцтэй Дадлагажигчдын тоонд мэс заслын/эмнэлзүйн хэмжээ хангалтгүй</p>	<p>4. Дадлагажигчдын тоонд хангалттай хүрэлцээтэй багш нар Дадлагажигчдын тоонд хангалттай нөөцтэй Дадлагажигчдын тоонд хангалттай мэс заслын/эмнэлзүйн үзүүлэлт Гол албан тушаалд боловсон хүчинтэй, үүнд: • Үндсэн мэргэшлийн (резидентийн) сургалтыг хариуцсан захирал • Вет лабораторийн зохицуулагч</p>
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

2. Энэхүү хөтөлбөр нь багш нарыг заах, хянах, суралцах болон цаг гаргах боломжийг олгоно. Багш нарын боловсролыг дээшлүүлэх (багшлах чадварыг сайжруулах), сургагч багш нарыг үнэлэх ёстой.

<p>1. Багш нарт хичээл заахад болон хяналт тавихад цаг байхгүй.</p>	<p>2. Багш нар хичээл заахад болон хяналт тавихад бага цагтай. Багш нарт СМЕ(Тасралтгүй үргэлжлэх анагаах ухааны боловсрол)-д хамрагдах цаг бага байдаг.</p>	<p>3. Багш нарт хичээл заах болон хяналт тавих хангалттай цагтай. Багш нарт СМЕ(Тасралтгүй үргэлжлэх анагаах ухааны боловсрол)-д хамрагдах цаг хангалттай.</p>	<p>4. Багш нарт хичээл заах болон хяналт тавих хангалттай цагтай. Багш нарт СМЕ(Тасралтгүй үргэлжлэх анагаах ухааны боловсрол)-д хамрагдах цаг хангалттай.</p>
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Хавсралт 11

Резидентийн Үнэлгээ

1. Резидентүүдийн ур чадварыг үнэлэх стандарт арга хэрэгсэл байдаг уу?

1. Албан ёсны үнэлгээ байхгүй	2. Зөвхөн анагаах ухааны мэдлэгийн үнэлгээ	3. Онолын мэдлэг ба гардан үйлдлийн ур чадварыг үнэлэх	4. Анагаах ухааны төгсөлтийн боловсролын магадлан итгэмжлэх зөвлөлөөс шаардах бүх ур чадварыг үнэлэх
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

2. Суралцагчдыг үнэлэхэд ямар хэрэглүүр ашигладаг вэ? Ашиглаж буй үнэлгээний төрлийг тодорхойлохын тулд доорх хүснэгтийг бөглөнө үү:

Үнэлгээний хэрэгсэл	Үнэлгээ	Хамгийн тохиромжтой давтамж	Тийм эсвэл Үгүй (хэрэв тийм бол төрөл ба давтамжийг тайлбарлах)	
Нүдний эмнэлзүйн ур чадварын үнэлгээний дасгал (OCEX) – Резидент ба өвчтөн хоорондын эмнэлзүйн харилцаа эсвэл үүнтэй төстэй байдлын үнэлгээ	Өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэх, харилцааны ур чадвар, анагаах ухааны мэдлэг	Жилд гурван удаа (Тухайн резидент ур чадвараа баталсан тохиолдолд үүнийг зогсоож болно)	T	Y
Нүдний мэс заслын ур чадварын үнэлгээний хүснэгт (OSCAR)	Мэс заслын ур чадвар	Хэрэв тохиолдлын тоо бага (<50) байвал аль болох олон удаа. Хэрэв >50 бол 3-5 тутамд 1	T	Y
ICO 360 эсвэл үүнтэй ижил төстэй	Мэргэжлийн ур чадвар, харилцааны ур чадвар	Жилд 1-2 удаа	T	Y
Илтгэх ур чадварын үнэлгээ	Илтгэл тавих, харилцааны ур чадвар	Резидентийн тавьсан илтгэл бүрт (эсвэл багшийн)	T	Y
Бичгийн шалгалт	Анагаах ухааны мэдлэг		T	Y
Аман шалгалт	Анагаах ухааны мэдлэг, өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэх		T	Y
Тохиолдолд суурилсан эмнэлзүйн ур чадварын үнэлгээ(OSCE)	Анагаах ухааны мэдлэг, өвчтөнд тусламж үйлчилгээ үзүүлэх, гардан үйлдлийн ур чадвар		T	Y
Төгсөлтийн дараах боловсролын үнэлгээний чухал үе шатууд эсвэл үүнтэй ижил төстэй	Сургалтын туршид резидентүүдийн ахиц дэвшлийг баримтжуулна	6 сар тутам	T	Y

3. Резидентүүдийн гүйцэтгэлийн талаар хэрхэн, хэзээ эргэн мэдээлэл өгөхийг тайлбарлана уу. Форматив /Завсрын/ эргэх холбоо нь резидентүүдэд тэдний ур чадварыг сайжруулахын тулд өгөх мэдээлэл юм. Дээр дурдсан үнэлгээний хэрэгслүүдийн ихэнх нь форматив шинж чанартай юм. Сумматив /Төгсгөлийн/ эргэх холбоо нь тойролтын төгсгөлд, эсвэл шалгалтанд тухайн резидент тэнцсэн эсвэл эс тэнцсэн эсэхийг тодорхойлох дүн юм.

Форматив³ /Завсрын/ эргэх холбоо

1. Форматив эргэх холбоогүй	2. Албан бусаар форматив мэдээлэл өгөх (төлөвлөгдөөгүй)	3. Жилд 2-оос доош удаа албан ёсны форматив мэдээлэл өгөх	4. Жилд 2-оос дээш удаа нарийвчилсан, үр дүнтэй форматив мэдээлэл өгөх
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Сумматив⁴ /Төгсгөлийн/ эргэх холбоо

1. Сумматив эргэх холбоогүй	2. Албан бусаар сумматив мэдээлэл өгөх (төлөвлөгдөөгүй)	3. Жилд 2-оос доош удаа албан ёсны сумматив мэдээлэл өгөх	4. Жилд 2-оос дээш удаа нарийвчилсан, үр дүнтэй сумматив мэдээлэл өгөх
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

³ Сургалтыг бататгахын тулд форматив эргэх холбоог ашигладаг. Энэ нь суралцагчийн ур чадвар, мэдлэг, суралцах зан үйлийг байнга сайжруулахын тулд гүйцэтгэлийн талаарх мэдээлэл өгөхөд чиглэгддэг. Энэхүү мэдээллийг суралцагчдад урьдчилан тодорхойлсон ур чадварт хүрэхэд зааварчилгаа өгөх, үнэлэхэд ихэвчлэн ашигладаг.

⁴ Сумматив эргэх холбоо нь суралцагчийн хичээл зүтгэлийг үнэлэж цаашид ахиж дэвшүүлэх шийдвэр гаргахад ашигладаг. Сумматив үнэлгээ ба эргэх холбоо нь цогц ойлголт бөгөөд энэ нь ихэвчлэн курс эсвэл модулийн төгсгөлд хийгддэг. Жишээлбэл, төгсөх шалгалт.

Хавсралт 12

Сургалтын орчин ба байгууллагын нөөц

1. Эмнэлэгт резидентүүдийг сургах хангалттай тоног төхөөрөмж бий юу? (завсарт гэрлийн биомикроскопи (slit lamp)-ийг сайн прокси болгон ашигладаг)

1. 4 резидент тутамд нэг эсвэл түүнээс цөөн тооны завсарт гэрлийн	2. 3 резидент тутамд нэг эсвэл түүнээс цөөн тооны завсарт гэрлийн	3. 2 резидент тутамд нэг эсвэл түүнээс цөөн тооны завсарт гэрлийн	4. Резидент бүрд нэг завсарт гэрлийн биомикроскопи
--	--	--	---

биомикроскопи оногддог.	биомикроскопи оногддог.	биомикроскопи оногддог.	оногддог.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

2. Нойтон эсвэл хуурай лаборатори байдаг уу? (Тийм эсвэл үгүй)

3. Хэрэв тийм бол:

а. Сэдэвчилсэн бүтэцтэй тойролт хийдэг үү?

1. Тодорхой бүтэц, зохион байгуулалтгүй хөтөлбөртэй.	2. Тодорхой бүтэцтэй боловч сургалтын зорилтыг заагаагүй.	3. Тодорхой бүтэц зохион байгуулалттай хөтөлбөртэй, сургалтын зорилгыг заасан, гэхдээ онол, арга зүйг тодорхой заагаагүй.	4. Тодорхой бүтэц зохион байгуулалттай хөтөлбөртэй, сургалтын зорилгыг заасан, онол, арга зүйг тодорхой заасан.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

б. Резидентүүдийг катаракт, глауком, птериgium, мэс заслын оёдол тавих гэх мэт чиглэл чиглэлээр сургахад зориулсан тоног төхөөрөмж, багаж, эмнэлгийн хэрэгсэл, материал байдаг уу? Хавсралт хэсгээс үзнэ үү!

Суурь болон ахисан түвшний нойтон лабораторит шаардлагатай материал, багаж хэрэгсэл байдаг уу? Хиймэл нүдэн дээр дадлага хийхэд шаардагдах бүтээгдэхүүн байдаг уу? Хавсралт хэсгээс үзнэ үү!

1. Тоног төхөөрөмж, мэс заслын багаж, эмнэлгийн хэрэгсэл дутагдалтай	2. Зөвхөн мэс заслын оёдол тавихад зориулагдсан тоног төхөөрөмж, мэс заслын багаж, эмнэлгийн хэрэгсэл байдаг	3. Зөвхөн мэс заслын оёдол тавих, птериgium, болрын мэс засалд зориулагдсан тоног төхөөрөмж, мэс заслын багаж, эмнэлгийн хэрэгсэл байдаг	4. Бүх тохиолдолд хэрэглэхэд зориулсан тоног төхөөрөмж, мэс заслын багаж, эмнэлгийн хэрэгсэл байдаг
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

с. Нойтон лабораторид резидентүүдийн чадавхийг баталгаажуулах, ахиц дэвшилд хяналт тавих үнэлгээний хэрэгсэл байдаг уу? Холбогдох бүх зүйлийг анхаарна уу:

Хэрэгсэл	Үнэлгээ	Тийм / Үгүй
----------	---------	-------------

Шалгалтын өмнө	Резидентүүдийн мэдлэгийн зөрөөтэй байдал: Нойтон лабораторийн ажилбарын талаархи мэдлэг, тухайлбал: ажилбарын үе шат, мэс заслын багаж, эмнэлгийн хэрэгслийн талаарх мэдлэг орно.	T	Y
Шалгалтын дараа	Шалгалтын өмнө тодорхойлсон мэдлэгийн зөрүүтэй байдлыг сургалтын үр дүнд арилгасан уу?	T	Y
OSCAR	Нойтон лабораторид гүйцэтгэх мэс заслын ур чадвар	T	Y

d. Нойтон лабораторид явагдсан сургалтын дараа резидентүүдтэй хамтарсан хэлэлцүүлэг, санал асуулга зохион байгуулах ажлыг тогтмол хийдэг үү?

1. Тодорхой бүтэц, зохион байгуулалтгүй хөтөлбөртэй.	2. Тодорхой бүтэцтэй боловч сургалтын зорилгыг заагаагүй.	3. Тодорхой бүтэц зохион байгуулалттай хөтөлбөртэй, сургалтын зорилгыг заасан, гэхдээ онол, арга зүйг тодорхой заагаагүй.	4. Тодорхой бүтэц зохион байгуулалттай хөтөлбөртэй, сургалтын зорилгыг заасан, онол, арга зүйг тодорхой заасан.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

e. Нойтон лабораторийн сургалтыг дэмжих чиглэлээр интернетэд суурилсан нөөц, боломжуудыг ашигладаг уу? Холбогдох зүйлсийг сонгох:

Хэрэгсэл	Тийм / Үгүй
Вебинарууд/Урьдчилан бичсэн лекцүүд	T Y
Онлайн курсууд	T Y
Сэтгүүлүүд	T Y
Урьдчилсан унших сэдвийн жагсаалт	T Y
Мэс заслын видео хичээлүүд	T Y

4. Танай байгууллагад сургалтын материал хангалттай байгаа юу? Тухайлбал:

Эмнэл зүйн суурь шинжлэх ухааны курс (Basic Clinical Science Course-BCSC) ном хангалттай тоогоор байгаа юу?

- Цогц сурах бичиг
- Номын сан

В. Сэтгүүл

1. Номын сан байхгүй	2. Эмнэл зүйн суурь шинжлэх ухааны курс ном (BCSC) > 5 жилийн өмнө хэвлэгдсэн номтой Их сургуулийн номын сан (цөөн тооны номтой) Тодорхой хугацаанд сэтгүүл унших боломжтой	3. Хамгийн багадаа сүүлийн таван жилд хэвлэгдсэн, нэг эмнэл зүйн үндсэн, суурь шинжлэх ухааны номны иж бүрдэлтэй (BCSC) Нүдний тасагт номын сантай (зарим номнууд) Wifi – тодорхой цагуудад сэтгүүл унших боломжтой	4. Резидентүүд шаардлагатай тоо хэмжээгээр авах боломжтой. Сэтгүүл унших боломжтой Wifi орчинтой Нүдний тасаг, их сургуульд хангалттай нөөцтэй номын сантай
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

5. Журнал клуб хийдэг үү?

1. Журнал клуб хийдэггүй	2. Журнал клуб хийдэг Гэхдээ тогтмол биш Жилд 1-ээс 2 удаа хийдэг.	3. Журнал клуб хийдэг. Хамгийн багадаа улирал тутам хийдэг. Гэхдээ сургагч багш нар оролцдоггүй.	4. Журнал клуб хийдэг. Хамгийн багадаа улирал тутам хийдэг. Сургагч багш нар оролцдог
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Хавсралт 13

Сургалтын үйл явцын үнэлгээ

1. Резидент болон багш нарын асуудлыг тодорхойлсон сургалтыг үнэлэх үйл явц байдаг уу? (Жишээ нь нэрээ нууцалсан резидентийн судалгааг хэр олон удаа хийдэг вэ?)

1. Байхгүй	2. Резидент болон ажилчдаас албан бус санал хүсэлт авах	3. Резидент болон ажилчдаас зарим үед албан ёсны судалгаа авах боловч энэ нь нэрээ нууцалсан судалгаа биш бөгөөд мөн тогтмолжоогүй	4. Жил бүр резидент болон багш нарын дунд нэрээ нууцалсан дэлгэрэнгүй судалгааг хийдэг
---------------	--	---	---

<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
--------------------------	--------------------------	--------------------------	--------------------------

2. Асуудлыг шийдвэрлэх, сайжруулах боломжийг олгохын тулд хөтөлбөрийн санал хүсэлтийн үйл явцыг ашигладаг уу? (сайжруулах төлөвлөгөө)

1. Ямар ч үйл ажиллагаа байхгүй	2. Албан бус санал хүсэлт дээр үндэслэн сайжруулах оролдлого хийдэг.	3. Албан ёсны судалгааны зарим хэлбэрийг ашиглан сайжруулах оролдлого хийдэг.	4. Хөтөлбөрийн үнэлгээ болон үйл ажиллагааны жагсаалт гаргах зорилгоор ажилчид болон резидентүүдтэй жил бүр тогтмол уулзалт хийдэг.
<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Хавсралт 14

Резидентүүдийн манлайлах, заах, дэмжих үр чадварын хөгжүүлэлт

1. Резидентүүдийн манлайлах, дэмжих болон заах чадварыг хөгжүүлэх стратеги байгаа юу? Холбогдох бүх зүйлсийг шалгана уу?

а.

Стратеги	Тийм / Үгүй
Резидент эмчийн удирдсан тойрон үзлэг (grand round)	Т Ү
Резидент эмчийн удирдсан лекц/илтгэл	Т Ү
Ахлах резиденттэй байх	Т Ү

б.

1. Байхгүй	2. Тойрон үзлэгийг зөвхөн багш нар зохион байгуулдаг. Танхимийн сургалтыг резидент эмч нар бус багш нар ихэнх тохиолдолд удирдаж явуулдаг.	3. Тойрон үзлэгийг зарим үед резидент эмч нар зохион байгуулдаг ба/эсвэл өвчтөний менежмент хийх талаар тодорхой төлөвлөө байхгүй. Резидент эмч нарын сургалтын зорилгоор заасан зарим илтгэл	4. Өвчтөний менежментийн тодорхой төлөвлөгөөтэй бөгөөд резидент эмч нар тогтмол тойрон үзлэг зохион байгуулдаг. Оюутнуудад тохирсон төлөвлөгөө бүхий 1-р курсын резидент эмч нарын сургалтыг нэг
---------------	---	---	---

		(лекцийн нэг хэсэг болгон) Ахлах резидент эмч ажилладаг боловч тохирох тодорхой төлөвлөгөө байхгүй	хэсэг болсон ахлах резидент эмч ажиллах загвартай Сургалтын зорилгоор резидент эмч нар илтгэл/ сургалтыг тогтмол хийх (лекцийн нэг хэсэг болгон)
□	□	□	□

Хавсралт 15

Резидентүүдийн явцын үнэлгээ

Энэхүү явцын үнэлгээ нь үндсэн мэргэшлээр суралцаж буй резидент эмчийн ур чадварын гүйцэтгэлийн хагас жилийн үнэлгээнд ашиглагдах хөтөлбөрт зориулагдсан. Нүд судлалын сургалтын хөтөлбөрт тусгагдсан үндсэн зургаан чадамж дараах дэд хэсгүүдээс бүрдэнэ:

1. Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээ ба Ажилбарын ур чадвар / Patient Care & Procedural Skills
 - Үйлчлүүлэгчтэй хийх ярилцлага / Patient interview
 - Үйлчлүүлэгчид үзлэг хийх / Patient examination (8 дэд үе шат)
 - Оношилгооны ажилбар ба Багаж хэрэгсэл / Diagnostic Procedures & Instruments (7 дэд үе шат)
 - Өвчний оношилгоо / Disease Diagnosis
 - Мэс заслын бус эмчилгээ / Nonsurgical therapy
 - Жижиг мэс ажилбар / Minor Surgery (3 дэд үе шат)
 - Мэс засал / OT Surgery (7 дэд үе шат)
 - Зөвлөгөө / Consultation
 - Нийгмийн нүдний эрүүл мэнд / Community Eye Health
2. Анагаах ухааны мэдлэг / Medical Knowledge
 - Зохих түвшний онолын мэдлэг / Level appropriate knowledge
 - Үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээний талаарх мэдлэг / Knowledge applied to patient care
 - Тоног төхөөрөмж ашиглах / Equipment maintenance
3. Мэргэжлийн ур чадвар / Professionalism
 - Энэрэнгүй, үнэнч шударга, хүндэтгэлтэй байх / Compassion, integrity and respect
 - Үйлчлүүлэгчийн хэрэгцээ, шаардлагад мэдрэмжтэй хандах / Responsiveness to patient needs
 - Үйлчлүүлэгчийн хувийн нууцыг хүндэтгэх / Respect for patient privacy

- Үйлчлүүлэгч ба нийгмийн өмнө болон мэргэжлийн хувьд хариуцлагатай байх / Accountability to patients, society and profession
4. Хүн хоорондын болон харилцааны үр чадвар / Interpersonal & Communication Skills
- Үйлчлүүлэгч ба гэр бүлийн хүмүүстэй үр дүнтэй харилцах / Communicate effectively with patients and families
 - Эмч, эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй үр дүнтэй харилцах / Communicate effectively with physicians and health professionals
 - Эрүүл мэндийн багийн гишүүн/ахлагчаар үр дүнтэй ажиллах / Work effectively as a member/leader of a healthcare team
- Дидактик болон тохиолдолд суурилсан материалыг үр дүнтэй танилцуулах / Effectively present didactic and case-based material
5. Практикт суурилан суралцах ба сайжрах / Practice Based Learning & Improvement
- Бие даан суралцах / Self-directed learning
 - Шинжлэх ухааны судалгааны нотолгоог олж, үнэлж, өөртөө шингээх / Locate, appraise, and assimilate evidence from scientific studies
 - Судалгааны диссертаци / Research Dissertation
6. Системд суурилсан практик / Systems Based Practice
- Эрүүл мэндийн тогтолцоо, тусламж үйлчилгээнд нийцүүлж үр дүнтэй ажиллах / Work effectively & coordinate care in health system
 - Зардлын хэмнэлт, мэдээлэл технологийн нэгдмэл байдлыг хангаж, аюулгүй/үр дүнтэй тусламж үйлчилгээг дэмжих / Incorporate Cost-effectiveness and IT to promote safe/effective care
 - Мэргэжил дундын багт ажиллах / Work in Inter-professional teams

Хагас жил тутамд резидентүүдийн үр чадвар, гүйцэтгэлийн түвшинг зохих үнэлгээний аргуудаар үнэлнэ. Үүнд:

- Аман эсвэл бичгийн шалгалт;
- Олон эх сурвалжийн эргэх холбоо (360 хэмийн үнэлгээ);
- Эмнэлзүйн үнэлгээний ажиглалт (CRS, OCEX);
- Ажилбарын ба мэс заслын үр чадварын үнэлгээ (OSCAR) орно.

Эмнэлзүйн сургагч багш нар үнэлгээний тайлангийн маягтын дагуу резидентүүдийн үр чадварын гүйцэтгэлийг хянаж, тэдний ахиц дэвшлийн талаарх санал бодлоо тэмдэглэх ёстой.

Сургалтын явцын үнэлгээг тогтмол хийхийн гол ач холбогдол нь тухайн суралцагч хоцрогдолтой байгаа эсэхийг тогтоох, эрт илрүүлж, амжилттай засч залруулах

боломж олгоно. Сургалтын жилээс хамааран чухал үе шатуудыг хүлээлт болгон хуваадаг. Түвшинг сонгох нь тухайн оршин суугч тухайн жилийн болон өмнөх оны үе шатуудыг мэдэгдэхүйц харуулж байна гэсэн үг юм.

Хавсралт 16

Үнэлгээний хүснэгт бөглөх загвар жишээ

- Резидент эмчийн гүйцэтгэлийг хамгийн сайн тодорхойлох түвшинг (нүд) сонгох **эсвэл**
- "Резидентийн өмнөх түвшинд хүрээгүй" сонголтыг сонгох

Үйлчлүүлэгчтэй хийх ярилцлага / Patient interview		
1-р жил	2-р жил	3-р жил
<p>1. Нүдний өвчний зовуурь, асуумж авах, анхан шатны маягт хөтлөх;</p> <p>2. Нүдний ерөнхий зовуурь, өвчний түүхээс үнэн зөв, чухал хамааралтай мэдээллийг олж авч чаддаг;</p>	<p>1. Эмнэлгийн бүртгэлээс гаруурх мэдээллийг олж авч нэгтгэдэг</p> <p>2. Өвчний сайн дураараа байдаггүй эмзэг, нарийн төвөгтэй, нарийвчилсан мэдээллийг багтаасан ялгавартай оношилгоо, оношлогооны төлөвлөгөөний аль алиныг нь мэдээлж, эрэмбэлэх хүүхдийн үйл явц зэрэг холбогдох түүхэн нарийн ширийн зүйлийг олж авдаг.</p>	<p>1. Эрүүл мэндийн багийн залуу гишүүд ялангуяа нүдний эмгэгийн эмзэг байдлын талаар өвчтөнөөс нарийн бөгөөд найдвартай мэдээлэл авахын тулд үлгэр дууриал болох ярилцлагын арга техникийг харуулдаг.</p> <p>2. Ярилцлагын асуултуудыг тохируулахын тулд мэргэжлийн шинэ мэдээллийг багтаасан</p>
